

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ 2007 – 2015



Бадрах, 2007



Нээлттэй
Нийгэм Форум



Орон нутгийн
удирдлага ба төрийн
үйлчилгээг шинэчлэх
санаачлага



Бодлого
судлалын төв



Тариалан сум

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форум болон Бодлого Судлалын Төвийн дэмжлэгтэйгээр Хөвсгөл аймгийн Тариалан сумын төр, захиргаанаас сумынхаа иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн төлөөлөлтэй хамтран оролцооны зарчмаар энэхүү стратегийг боловсруулав. Нээлттэй Нийгэм Хүрээлэн, «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага», Нээлттэй Нийгэм Форум энэхүү стратегийн агуулга, мэдээллийн баталгаажилт, чанарын талаар хариуцлага хүлээхгүй.

DDC

338,9'517

Э-17

ISBN 978-99929-0-375-9

Хянан тохиолдуулсан: Б.Мөнхсоёл, Ц.Хөвсгөлдалай, Д.Батжаргал,
С.Амгаа, Б.Эрдэнэбаатар

Эхийг бэлтгэсэн: М.Амгалан
Хавтасны дизайнер: Ц.Одончимэг

Хэвлэсэн газар: «ADMON», Монгол

© Зохиогчийн эрхийг Хөвсгөл аймгийн Тариалан сумын ЗДТГ эзэмшинэ.

Гарчиг

| | |
|------------------------|-----|
| Өмнөтгөл | v |
| Товчилсон үг | vi |
| Өмнөх үг | vii |
| Оршил | ix |

Бүлэг 1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн нийтлэг асуудлууд 1

| | |
|---|---|
| 1.1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн ач холбогдол | 1 |
| 1.2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндэслэл | 3 |
| 1.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн мөн чанар, агуулга | 5 |

Бүлэг 2. Стратеги боловсруулах үйл ажиллагаа 7

| | |
|---|----|
| 2.1. Үндсэн зарчим, арга зүй | 7 |
| 2.2. Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын ба зохицуулалтын арга хэмжээ | 9 |
| 2.3. Олон нийтийн оролцоо ба зөвшилцөл | 13 |
| 2.4. Бизнесийн орчны судалгаа | 14 |
| 2.5. СВОТ шинжилгээ | 15 |
| 2.6. Алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл | 16 |
| 2.7. Хүлээгдэж буй үр дүн | 18 |
| 2.8. Стратегийг хэрэгжүүлэх | 18 |
| 2.9. Стратеги хэрэгжүүлэх зохион байгуулалтын асуудлууд | 19 |
| 2.10. Стратегийн санхүүжилт | 20 |

Бүлэг 3. Тариалан сумын танилцуулга 21

| | |
|---|----|
| 3.1. Газар зүй, цаг уурын нөхцөл, байгалийн нөөц баялаг | 22 |
| 3.2. Эдийн засгийн үндсэн ба туслах салбар | 23 |
| 3.3 Хүн ам зүй, хүний нөөц, чадавхи | 25 |
| 3.4. Нутгийн удирдлагын зохион байгуулалт, үйлчилгээ | 26 |
| 3.5. Дотоод, гадаад харилцаа | 28 |

| | |
|--|-----------|
| Бүлэг 4. Сумын эдийн засгийн тойм | 30 |
| 4.1. Сумын эдийн засгийн хөгжлийн одоогийн байдал, хэтийн төлөв | 30 |
| 4.2. Ажиллах хүчний чадавхи, хангамж, хүрэлцээ | 32 |
| 4.3. Дэд бүтэц, үйлчилгээ | 34 |
| 4.4. Зах зээл, маркетинг | 37 |
| 4.5. Суманд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд | 38 |
| | |
| Бүлэг 5. Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги | 39 |
| 5.1. Бизнесийн орчны судалгааны дүн | 39 |
| 5.2. СВОТ шинжилгээ | 46 |
| 5.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн агуулга | 49 |
| 5.4. «Алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл» матриц | 50 |
| 5.5. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн хэрэгжилтийн матриц | 53 |
| 5.7. Төслийн эрэмбийн матриц | 60 |
| 5.7. Бизнесийг дэмжих стратегийн чиглэлүүд | 63 |
| 5.9 Төслийн товч танилцуулга | 68 |

ӨМНӨТГӨЛ

Монгол шиг шилжилтийн эдийн засагтай орнуудын хөгжлийн тэргүүлэх зорилгуудын тоонд шинээр төрөн гарч буй хувийн хэвшлийнхэнд зориулж бизнес эрхлэх тааламжтай орчин бүрдүүлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжилд (ОНЭЗХ) зориулсан нэгдмэл, олон талт төлөвлөгөөг өөрсдийн санаачилгаар боловсруулах явдал ордог.

Сүүлийн жил гаруй хугацаанд Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Нээлттэй Нийгэм Форумас Монгол улсын 4 суманд орон нутгийн ард иргэдийн цаашдын хөгжлийн хэрэгцээгээ илүү сайн төлөвлөж, удирдах чадавхийг бэхжүүлэх ажлыг санаачилан хэрэгжүүлж байна. Энэхүү «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх нь» (DELTA) хэмээх төслийг өмнө нь ННХ, Дэлхийн Банкнаас Зүүн Европт хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн хэрэгжүүлсэн юм. Үүний үндсэн санаа нь орон нутгийн хүн амын томоохон бүлгүүд, түүний дотор төр засаг, хувийн хэвшил, иргэний нийгмийнхэн хамтран хөгжлийн таатай нөхцөл, боломжуудыг шинжлэх, алсын хараа, зорилго, зорилтуудаа тодорхойлох, улмаар тэдгээрт хүрэхэд чиглэсэн тодорхой, ач холбогдол бүхий төсөл, алхмуудыг боловсруулж гаргахад оршиж байсан юм.

Таны өмнө байгаа стратегийн баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь тус төслөөс гарч буй хамгийн анхны биет үр дүнгүүд юм. Харин сумын түвшинд бий болоод байгаа хөгжлийн шинэ түншлэлүүд, тухайн сумдын «бизнес эрхэлж» байгаа шинэ арга барил буюу илүү олныг хамарсан, оролцоот хэлбэр нь нүдэнд тэр бүр ил харагдахгүй үр дүнгүүд юм. Цаашид энэхүү төлөвлөлтийн арга зүйг бусад янз бүрийн шийдвэр гаргах үйл явцад хэрэглэх боломжтой, хэрэглэх ч ёстой юм.

Энэ завшааныг тохиолдуулан Хөвсгөл аймгийн Тариалан сумын ард иргэд, Бодлого судлалын төвийнхөн болон энэхүү стратегийг амжилттай боловсруулахад хувь нэмрээ оруулсан бусад бүх мэргэжилтнүүдэд талархлаа илэрхийлэхийг хүсч байна.



П.Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал



Скотт Абрамс
Будапештийн ННХ-ийн Орон нутгийн
захиргаа, төрийн албаны шинэчлэлийн
санаачилгын Орлогч захирал

Товчилсон үг

| | |
|----------|--|
| ОХАТОНЭХ | Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх |
| ОНЭЗХС | Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэр |
| ДЕЛТА | «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх» төслийн англи нэрийн эхний үсгийн хураангуй |
| СЭЗХС | Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурал |
| ИТХТ | Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид |
| ААН | Аж ахуйн нэгж |
| ХХААГ | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| ННФ | Нээлттэй Нийгэм Форум |
| ОНУТУШС | Орон Нутгийн Удирдлага, Төрийн Үйлчилгээг Шинэчлэх Санаачлага |
| БСТ | Бодлого Судлалын Төв |
| ННХ | Нээлттэй Нийгэм хүрээлэн |
| ОУБ | Олон улсын байгууллага |
| МТС | Машин тракторын станц |



Өмнөх үг

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт үндсэндээ шувтарч, улс орны эдийн засгийн хөгжлийн явц тэнцвэржих, эдийн засгийн өсөлт бий болж тогтворжих бодитой үйл явц өрнөж байгаа өнөөгийн нөхцөлд орон нутгийн эдийн засгийн хөгжлийн хэтийн чиглэлийг оновчтой зөв тодорхойлох шаардлага зайлшгүй тулгарсан юм. Монгол улсын хөгжлийн энэхүү зурвас үед Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага, төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форумоос сумын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх - ДЕЛТА» төслийг тусгай шалгуураар сонгосон зарим сумдад хэрэгжүүлсний дотор Хөвсгөл аймгийн Тариалан сум багтсан билээ. Уг төслийн шууд дэмжлэгтэйгээр сумынхаа эдийн засгийн хөгжлийн дунд хугацаа (2007-2015 он)-ны стратеги боловсрууллаа.

Орон нутгаа хөгжүүлэхийг эрмэлзсэн олон нийтийн нийтлэг зорилго, хөгжлийн шинэ эринд алхан орох хүрэх хүсэл тэмүүллийг оновчтой томъёолсон эдийн засгийн хөгжлийн стратеги (ЭЗХС) боловсруулах ажлын хүрээнд сумын төр захиргаа ба хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөгжлийн үйл явцад олон нийтийн оролцоо, хувь нэмрийг өргөжүүлэх замаар сум орны бизнесийн цаашдын хөгжилд таатай орчныг бүрдүүлэхэд ДЕЛТА төсөл зохих ёсоор нөлөөлсөн гэж үзэж болно.

Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэх шаардлага, сумын онцлогт нийцүүлэн сонгосон төслүүдийг ЭЗХС-ийн үндсэн бүрдэл хэсгийн хэмжээнд ач холбогдол өгч нарийвчилсан тодорхойлолттойгоор тусгалаа. Ингэснээр стратегийг үр өгөөжтэй хэрэгжүүлэх магадлал улам нэмэгдэнэ хэмээн найдаж байна. Хувийн хэвшлийг дэмжихэд төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, бизнесийн орчныг сайжруулах олон талт зорилго, зорилттой нягт уялдуулан төлөвлөсөн учраас энэхүү стратегид тусгагдсан төслүүд хэрэгжих баталгаа сайтай болсон гэж үзэх үндэслэлтэй. Бизнесийг дэмжих чиглэлүүдийг амьдралд бодитой

хэрэгжүүлэх явдал нь жижиг дунд үйлдвэр (ЖДҮ)-ийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зэрэг үндэсний хөгжлийн зангилаа асуудлыг орон нутагт бодитой хэрэгжүүлэх боломж олгож буйн зэрэгцээ сумын төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр үзүүлнэ.

Орон нутагт, түүний дотор сумдад үйлдвэрлэл, үйлчилгээ дорвитой хөгжихгүй байгаагийн нэг шалтгаан нь төсөв, санхүүжилтийн эх үүсвэр байнга дутагддаг явдал юм. Цаг үеийн чанартай, түр зуурын арга хэмжээгээр сумын эдийн засгийн хөгжлийг тэтгэх, идэвхжүүлэх боломжгүй нь нэгэнт нотлогдсон учраас шинэлэг арга хэлбэрийг санаачлан хэрэгжүүлэх ёстой болсон билээ. Алсын хараа, зорилго, зорилт, хөтөлбөр гэсэн шаталбартайгаар төлөвлөсөн ЭЗХС-ийг эцэслэн хэрэгжүүлэх арга зам хэмээн хөгжлийн төслүүдийг сонгосон нь арга зүйн зарчмын шинэ хандлага болсон юм.

Үйл ажиллагааны төлөвлөгөө хэмээх хуучирсан хэлбэрийн оронд төслүүдийг сонгосноороо манай сумын ЭЗХ-ийн стратеги шинэлэг төдийгүй, нэгдсэн ба орон нутгийн төсөв болон хандивчлагчдын янз бүрийн эх үүсвэрээс санхүүжилт, хөрөнгө оруулалт олох боломжийг урьд өмнө байгаагүй хэмжээгээр нэмэгдүүлж байгаа юм.

Монгол улсын 330 гаруй сумдаас ДЕЛТА төслийг хэрэгжүүлэхээр шалгаран сонгогдож, сумынхаа хүч бололцоог дайчлан ажилласныхаа хүчинд ЭЗХ-ийн стратеги хэмээх чухал баримт бичгийг иж бүрэн боловсруулж гаргаснаараа орон нутгийн эдийн засгийн хөгжлийг цэгцтэй бодлого, уялдуулан зохицуулсан стратеги, олон нийтийн чин хүсэл, идэвхтэй оролцоонд тулгуурлан хөгжүүлэх асуудлыг үлгэр жишээчээр шийдвэрлэх боломж бидний өмнө нээгдэж байна.

Нэр хүнд бүхий олон улсын хэмжээний томоохон хандивлагч, үндэсний мэргэжлийн байгууллагаас арга зүйн удирдамж, дэмжлэг авч, сумынхаа нийт иргэд, төрийн ба иргэний нийгмийн байгууллагууд, бизнес эрхлэгчдийн шууд оролцоотойгоор боловсруулсан ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд өөрсдийн хүч хөдөлмөр, мэдлэг чадвар, туршлага, нөөц боломжоо дайчлах тус сумынхны чин сэтгэл, идэвх санаачлага, зүтгэл хамгаас чухал хэдий ч хандивлагчид, гадаад орны засгийн газар, олон улсын байгууллага, санхүүгийн түншүүд, хөрөнгө оруулагчдын санхүүгийн ба техникийн тусламж, дэмжлэггүйгээр үр дүнд хүрэх боломж нэн хомс юм.

Үүний учир энэхүү товхимлыг өргөн толилуулахын ялдамд манай сумын эдийн засгийн хөгжил, хүн ардын сайн сайхны төлөө бидэнтэй хамтран ажиллах талаар хандивлагчид, хөрөнгө оруулагчид, санхүүгийн ба иргэний нийгмийн байгууллагуудаас гаргасан аливаа санал санаачлагыг бүрнээ хүлээн авч дэмжин ажиллах болно гэдгээ илэрхийлж байна.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын засаг дарга Ц.Хөвсгөлдалай

Оршил

Монгол улсыг бүхэлд нь хамарсан эдийн засаг-нийгмийн шинэчлэлтийн хүрээнд тус сумын хөгжлийн хүрсэн түвшинг хадгалах, цаашид ахиулах, үр ашгийг нь олон нийтэд жигд хүртээхэд сумын төр, захиргааны байгууллага, бизнес эрхлэгчид түлхүү анхаарах явдал хойшлуулшгүй зорилт болж байна. Ирээдүйд хөгжил өргөжин тэлэх суурь болох шинэ зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх асуудал хөгжлийн шинэ зорилготой холбогдон сумынхны өмнө чухлаар тавигдаж байна.

Зах зээлд шилжих явцад болон шилжилтийн дараах жилүүдэд сумын эдийн засгийн хөгжил, бизнесийн бүтэц, чадавхид олон чухал дэвшил, өөрчлөлтүүд бий болсон бөгөөд энэ үйл явц одоо ч үргэлжилсээр байна. Зах зээлд шилжихээс өмнө төрийн өмчийн том аж ахуйнууд үйлдвэрлэл, үйлчилгээнд давамгайлж байсан бол эдүгээ хувийн өмчид суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл энэхүү байр суурийг эзэлсэн явдал эдийн засаг, бизнесийн хөгжлийн асуудлыг шинэлэг арга барилаар авч үзэх бодит шаардлагыг бий болгож байгаа гол хүчин зүйл юм.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг сумын түвшинд хангахад туслалцаа дэмжлэг авах, санхүүжилтийн эх үүсвэр олохын тулд хандивлагчид, хөрөнгө оруулагчдыг татах дорвитой арга хэмжээ хэрэгжүүлж, амьд ажил өрнүүлэх цаг үе ирээд байна. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг орон нутгийн бизнес орчныг сайжруулах чиглэлд улам гүнзгийрүүлэх хэрэгтэй байна. Сумын төр, захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагуудаас дүрэм журам, зохицуулалт гаргахдаа сумынхаа эдийн засгийг цэцэглүүлэн хөгжүүлэхийн тулд бизнес эрхлэгчдээс идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжийг хангах, тэдэнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх явдлыг эн тэргүүнд тавьдаг байх нь зүй ёсны шаардлага төдийгүй шинэ хандлага, шинэ арга барилын үндсийн үндэс болох учиртай.

Сумынхаа бизнесийг идэвхжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, хүн амын амьдралын чанарыг тасралтгүй сайжруулахад орон нутгийн бизнесийн өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх шинэ үзэл баримтлал, шинэлэг арга замаар хандах нэн төвөгтэй үүрэг хариуцлагыг орон нутгийн удирдлага, бизнес эрхлэгчид өөртөө хүлээх шаардлагатай боллоо. Ийм нөхцөлд одоо үйл ажиллагаа явуулж буй бизнесийг тогтворжуулан чадавхижуулах, шинээр бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтыг татах харьцангуй таатай нөхцлийг бүрдүүлэх явдлыг сумын захиргаа стратегийн зорилтын хэмжээнд тавьж ажиллах ёстой юм. Цаад агуулгаараа, нөөц боломжоо орон нутгийнхаа хөгжлийн төлөө зохистой ашиглах, хэрэглэгчдийн эрэлт таашаалд нийцсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг зах зээлд гаргах тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэлүүдээ оновчтой тодорхойлох, энэ дагуу дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийг иж бүрнээр боловсруулахад сумынхан

өөрсдөө ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай гэсэн үг. Сумын эдийн засгаа амжилттай хөгжүүлж, тогтворжуулах асуудалд ийн хандваас бүх боломж, нөөцөө хамгийн ухаалгаар, үр өгөөжтэй ашиглах зохистой арга замаа олж сая чадна.

Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги (ЭЗХ)-ийн зорилго, зорилт, төслүүдийнхээ харилцан уялдааг сайтар хангах асуудлыг олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны үндсэн дээр гүйцэтгэх, түншүүд, оролцогчдын чадавхи, чин эрмэлзлийг тусгасан байх зарчмыг стратеги боловсруулах явцад барьж ажиллав. Ийнхүү нийтээр чармайн ажиллаж сумын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах ажлаа амжилттай дуусгалаа. Эдийн засгаа хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд сумынхны бүх бүлэг, давхарга өөрийн оролцоо, хувь нэмрээ оруулах боломжийг энэ стратеги бүрдүүлж өгснийг тэмдэглэх нь зүйтэй.



БҮЛЭГ 1

СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН НИЙТЛЭГ АСУУДЛУУД

1.1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн ач холбогдол

Юуны өмнө, сумын эдийн засгийн хөгжлийн иж бүрэн стратегитэй болсон явдал ДЕЛТА төслөөс тус суманд үзүүлсэн, бодитой дэмжлэгийн шууд үр дүн мөн гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сумын удирдлага, бизнес эрхлэгчид, иргэд орон нутгийнхаа хөгжлийн тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлаар «нүүр улайхгүй ярих, хэлцэх» нэн чухал боломжоор хангагдлаа хэмээн стратегийнхээ ач холбогдлыг зангидан томъёолж байна. Сумынхны хүсэл тэмүүлэл, чин эрмэлзлийг тусгасан «Эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги» нь хөгжлийн асуудлаар өргөн хүрээтэй түншлэл, хоршилт, хамтын ажиллагааг өрнүүлэх хэтийн удирдамж болохоос гадна сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн явц, өрнөлийг үнэлэх, хожим дэвшигдэн гарах шинэ зорилго, зорилтыг олон нийтийн оролцоотойгоор тодорхойлон шийдвэрлэж байх шаардлагад төгс нийцсэн баримт бичиг болж чадсан юм.

Сумын хөгжлийн ирээдүйн чиг баримжаатай холбоотой үзэл баримтлалын ба стратегийн чиглэлүүдийг тодорхойлох, шинэчлэн томъёолох хэрэгцээ шаардлага цоо шинээр гарч ирээгүй, ДЕЛТА төслөөс өмнө ч гэсэн яригддаг байсан билээ. Сумын төр захиргааны ба төрийн үйлчилгээ эрхлэх байгууллагуудын хувьд олон жилийн өмнөөс тулгамдсаар ирсэн энэ асуудлыг зохистой шийдвэрлэн хэрэгжүүлэх боломж харахан гараагүйд хэргийн учир оршиж байгаа юм. Энэ талаас нь авч үзвэл ДЕЛТА төслийг манай суманд хэрэгжүүлсэн явдал цаг үеэ олсон чухал үйл явдал боллоо.

Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг сайжруулах, орон нутгийн бизнесийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангахад таатай орчинг бүрдүүлэх, орон нутгийн бизнесийг дэмжихэд сумын удирдлагын зүгээс тавьж буй хүчин чармайлтыг оновчтой чиглүүлэх асуудлууд бодитой тулгарахын цагт үр өгөөжтэй, хэрэгжих боломжтой стратегийг хэтийн баримжаатай боловсруулах арга зүйн, мэргэжлийн дэмжлэг, мэдээлэл, чадавхи дутагддаг, тэр чинээгээр сумын хөгжил саатахад хүрдэг байсан юм.

Орон нутгийн эдийн засгийг зах зээлд нийцүүлэн салбарлуулан өргөжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг зохистой өөрчлөх талаар сумын төр, захиргааны зүгээс зохих хүчин чармайлт тавьж ирсэн билээ. Хамгийн гол нь бүтээлч түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд сумын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зохистой механизм бий болгох, зах зээлийн зөв гольдролд оруулахад тэдгээр арга хэмжээ төдийлэн үр бүтээлтэй болж чадаагүй юм.

Эдүгээ суманд байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний бизнес тэр бүр санасан хэмжээгээр өргөжин тэлэхгүй, шинээр бизнес эрхлэх санаачлага оролдлого бүхэн ажил хэрэг болж харахан чадахгүй байгаа нь бизнесийн өсөлтийг дэмжих санхүүгийн найдвартай эх үүсвэр дутмаг байгаатай холбоотой. Түүнээс гадна бизнес эрхлэх орчин нь бизнесийн чадавхийг дээшлүүлэхэд тэр бүр тааламжтай бус байгаа явдал зохих сөрөг нөлөөтэй гэж дүгнэж болно.

Ер нь сумын төр, захиргаа нь эдийн засгийн хөгжил, бизнесийн дэвшлийг идэвхгүй ажиглагч юм уу хөндлөнгөөс шууд оролцогч биш, харин эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, амьдралын чанарыг дээшлүүлэх гол нөхцөл болох бизнесийг хөгжүүлэхэд эрхзүйн зохицуулалт болон шаардлагатай бусад дэмжлэгийг үзүүлдэг, үйл ажиллагаандаа хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэхийг бүх талаар эрмэлздэг, өөрөө санаачилдаг, олон нийтийг манлайлан чиглүүлдэг түнш байхыг туйлаас эрхэмлэх цаг ирээд байна.

Сумын төр, захиргаа нь янз бүрийн сонирхол бүхий бизнесийн ба иргэний нийгмийн бүлгүүдийг хөгжлийн асуудал дээр зохион байгуулж төвлөрүүлэх,

хамтран ажиллах арга хэлбэрээр тэднийг дэмжих бүрэн чадавхитай байгууллага мөн болохыг стратеги боловсруулах явцад хуримтлуулсан туршлага маань харууллаа. Олон улсын байгууллагаас үзүүлсэн дэмжлэгийн ачаар орон нутагтаа бизнесийг дэмжин хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулахад төр, захиргааны зүгээс явуулах үйл ажиллагааны механизмаа тодорхойлж авлаа, шинээр сэтгэх, ажиллах таатай нөхцөл бүрдлээ.

ДЕЛТА төслийг хэрэгжүүлэхэд оролцсон хандивлагч ба хэрэгжүүлэгч байгууллагууд, төслийг гүйцэтгэгчид, бидний хамтын чармайлтаар бүтсэн эдийн засгийн хөгжлийн стратеги маань манай сумын эдийн засаг, бизнес цэцэглэн хөгжих баталгаа болж чадсан гэдэгт гүнээ итгэж байна.

1.2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндэслэл

Сумынхнаа олон нийтийн чин эрмэлзэлд тулгуурлан тэдний идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр анх удаа боловсруулсан сумын ЭЗХ-ийн стратеги нь орон нутгийн эдийн засаг ба бизнесийн хөгжлийг дэмжих орчинг боловсронгуй болгох талаар тулгамдаж буй болон ирээдүйн чиг хандлагатай холбоотой нэн тэргүүний асуудлыг оролцооны зарчимд тулгуурлан тодорхойлох хамгийн дөхөмтэй, хэрэгжих боломжтой арга замыг эрэлхийлсэн хамтын хүчин зүтгэлийн үр дүн билээ. Тэргүүлэх ач холбогдолтой хэмээн хамтаараа тодорхойлсон зорилгоо амжилттай хэрэгжүүлснээр стратегийн үр шимийг олон нийтэд хүртээх, олон нийтийн зүгээс зүй зохистой хүртэх суурь нөхцлийг бүрдүүлж чадах юм.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төрийн үйлчилгээг сумын төр, захиргаанаас хэрэгжүүлж буй арга зам, хэлбэр нь эргээд эдийн засгийн дотоод боломж, давуу байдал, гадаад таатай нөхцлийг аль болох өгөөжтэй ашиглах, бизнесийг тогтоон барих, өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр явуулах үйл ажиллагааны чанар, үр дүнд шууд болон дам нөлөө үзүүлдэг, тэр чинээгээр орон нутгийн эдийн засаг, бизнест зайлшгүй харгалзах хүчин зүйл юм. Бизнес эрхлэгчид, байгууллага, иргэдэд тэгш үйлчлэх орчинг бүрдүүлэх явдал төр, захиргааны үндсэн зорилго мөн. Аливаа бизнесийн хүрээ, түүний хэмжээ далайц нь үнэн чанартаа, бизнестэй орчныг бизнестэй холбодог хүчин зүйл хараахан биш. Энэ ч учраас сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах явцад өмчлөл, зохион байгуулалтын хэлбэр, хэмжээгээр нь ялгаварлахгүйгээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэд, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах нийтлэг зарчмыг сумын төр, захиргаанаас баримталсан болно.

Орон нутгийн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сумын эдийн засгийн хөгжилд таагүй нөлөөлж байгаа, нөлөөлж болзошгүй орчны болон бусад

хүчин зүйлсийг залруулах, зөөлрүүлэх, саад бэрхшээл, эрсдэлийг багасгах, даван туулах арга замыг агуулгын болоод хэлбэрийн хувьд оновчтой сонгоход стратегийн үндсэн баримжаа чиглэсэн болно. Стратегийн гол томъёолол, бүтцийг эцэслэн боловсруулахаас өмнө явуулсан бизнес орчны судалгаа болон СВОТ шинжилгээ нь эдийн засаг, бизнесийн хөгжлийн одоогийн байдал, хүрсэн түвшинг тодруулах, хэтийн чиглэл хандлагын талаар сумынхны үнэлэмж, төсөөлөлтэй холбоотой суурь мэдээлэл бүрдүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Сумын төр, захиргаа болон олон нийтийн хамтын хүчин чармайлтын бодит үр дүн, эдийн засгийн хөгжлийн илүү өндөр түвшинд хүрэхийн төлөө иргэд, бизнесийнхэн, төр, олон нийтийн байгууллагуудын нийтлэг хүсэл тэмүүлэл, сум орны хөгжлийн ирээдүйн тухай санал төсөөллийг төлөөлж байгаа гэдэг үндэслэлээр бидний боловсруулсан дунд хугацааны стратегийн агуулгыг нь тодорхойлох боломжтой.

Сумынхаа орчмын бүс нутгийн хүний ба байгалийн нөөц, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн төлөв байдал, соёл, түүхийн өв сан зэрэг чухал ач холбогдол бүхий хэд хэдэн хүчин зүйлсийг стратеги боловсруулахад харгалзан үзсэн болно. Эцэст нь, манай сумын харьцангуй давуу талууд, олон нийтийн идэвх зүтгэл, чин эрмэлзэлтэй холбоотой аливаа боломж бүхнийг стратегид тусгахыг эрмэлзлээ.

«Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай» хуулийн 8 дугаар зүйлийн 1-д «Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь ...нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж...», «Сум, дүүргийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй» хэмээн нутгийн өөртөө удирдах байгууллагын бүрэн эрхийг, мөн хуулийн 18.1.2-ийн «а»-д «нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;» хэмээн заасан нь сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах эрх зүйн үндэслэл болж өглөө.

Хувийн хэвшлийнхнээс ихээхэн идэвх чармайлт, санаачлага гаргаж сумын төр захиргаатай хамтран ажиллаагүйсэн бол стратеги боловсруулах тухай бодохын ч хэрэггүй байсныг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Стратеги боловсруулах үйл ажиллагаа нь өөрөө сумынхны дунд зохих хүлээлт бий болгосон төдийгүй хүлээлтээ амжилттай, бодит үр өгөөжтэй ажил хэрэг болгох, стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг хариуцлагын талаар энэ ажилд оролцсон, хувь нэмрээ оруулсан хүмүүс нийтлэг ойлгоцтой боллоо.

Бүтээлч хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр жимс болсон стратеги маань амжилттай хэрэгжинэ гэдэгт сумын төр, захиргааны байгууллага, иргэд, бизнес

эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд бүрэн итгэж байна. Стратегид тусгасан төсөл, бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлээ үр дүнтэй хэрэгжүүлэх замаар алсын хараа, зорилго, зорилтдоо хүрэхэд байгаа нөөц боломжоо туйлын зохистой хуваарилан ашиглах болон чадавхи, давуу талаа хариуцлагатай зохицуулах асуудал олон нийтэд үр өгөөжийг хүртээх боломжийг хангах талаасаа нэн чухал гэдгийг цохон тэмдэглэж байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2007 оны долоодугаар сарын 08-ны өдрийн 6 дугаар хуралдаанаар Тариалан сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг хэлэлцэн сумын хөгжлийн дунд хугацаа (2007-2015)-ны хөгжлийн чиг баримжаа, ялангуяа бизнес хөгжих орчныг сайжруулах, төрийн үйлчилгээг шинэ шатанд гарган сайжруулах алсын харааг оновчтой томъёолж, энэ хүрээнд стратегийн зорилго, зорилтууд, төслүүдийг зөв тодорхойлж чадсан гэж үзэн санал нэгтэй сайшаан баталсан болно.

1.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн мөн чанар, агуулга

Бизнесийн орчинг цаашид улам сайжруулж, боловсронгуй болгоход олон нийтийн оролцоо, хүчин чармайлтыг дэмжин идэвхжүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хандивлагчид, хөрөнгө оруулагчдаас дэмжлэг тусалцаа үзүүлж болох гол чиглэлүүдийг оролцооны зарчмаар тогтоосон явдал стратегийн гол агуулгыг тодорхойлж байна. Орон нутагтаа бизнес хөгжүүлэх орчныг сайжруулахад тулгамдаж буй цаг үеийн ба алс хэтдээ шийдвэрлэвэл зохих асуудлуудын талаархи олон нийтийн ойлголт мэдлэг, төсөөлөл хандлага дээр тулгуурлан стратегийг боловсруулсан нь түүний мөн чанарыг илэрхийлнэ.

Арга зүйн хувьд орон нутгийн эдийн засгийн хөгжлийг төлөвлөхөд баримталж байгаа сүүлийн үеийн үзэл баримтлал, онол-практикийн үндсэн асуудлуудыг стратеги боловсруулах ажиллагааны бүх шатанд харгалзсан болно.

Тариалан сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн гол зарчмыг товчлон тодорхойлбол:

- Дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг хангах асуудлыг сумын төр, захиргаа, иргэд, бизнесийн ба олон нийтийн байгууллагатай бүх түвшинд холбох замаар эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг чанаржуулах,

- Бизнесийг өргөжүүлэх, салбарлуулан хөгжүүлэх, шинээр бизнес эхлэхэд бизнесийн орчноор дамжуулан сумын төр, захиргаанаас үзүүлэх дэмжлэгтэй холбоотой төслүүдийг оролцогчдын туршлага мэдлэг, санал төсөөлөл дээр үндэслэн тодорхойлох,
- Орон нутгийн бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг нэгтгэх замаар хөгжлийн алсын хараа, нийтлэг зорилгоо стратегийн хэлбэрээр нэгтгэн тодорхойлох жишээг сумын олон нийтэд бодитойгоор харуулах,
- Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн дэвшлийг хангах, өсөлт бий болгох, олон нийтийн бүтээлч оролцоо, хувь нэмрийг өргөжүүлэхэд оролцогчдыг хөтлөх хэрэглүүр болох талаас нь стратеги төлөвлөлтийг таниулан ойлгуулах,
- Санхүүгийн ба техникийн дэмжлэг үзүүлдэг хандивлагчид, хөрөнгө оруулагчдад хандах, нөлөөлөх арга хэрэглүүр болгон ашиглах үндэслэл, боломжтой нь холбон стратегийг хүлээн авах нийтлэг хандлага, ойлголтыг олон нийтийн дунд бэхжүүлэх,
- Хамтач уур амьсгалыг бэхжүүлж, нээлттэй, ажил хэрэгч байдлыг хангах, эдийн засаг, бизнесээ цэцэглүүлэн хөгжүүлэх хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй орчинг бүрдүүлэх зэрэг болно.



БҮЛЭГ 2

СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Үндсэн зарчим, арга зүй

Олон нийтийн идэвхтэй, чин эрмэлзэлт оролцоог хөхүүлэн дэмжих янз бүрийн арга хэрэгслийг ашиглах боломжийг хангах үндэслэлээр эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ зорилгоор бий болгосон албан ёсны бүтцийн хүрээнд болон нээлттэй хэлэлцүүлэг, зөвшилцөл зэрэг арга хэмжээгээр дамжуулан олон нийтийг стратеги боловсруулах үйл ажиллагаанд оролцуулж чадлаа. Олон нийтийн саналын үндсэн дээр сумын эдийн засаг, бизнесийн хөгжил, тогтвортой өсөлтийг хангах нийтлэг ба гол гогцоо асуудлаа хамтын оюун ухаанаар тодорхойлох зарчмыг хангахад стратеги боловсруулах үйл ажиллагааг бүхэлд нь чиглүүлэв.

Үндсэн зарчим. Тариалан сумын ЭЗХ-ийн стратегийг боловсруулахад баримталсан гол зарчмууд:

- Эдийн засгийн өсөлт, бизнесийн хөгжлийг нийгмийн амьдрал, байгаль орчин, иргэдийн амьжиргааны чанарын тулгамдсан асуудлуудтай холбох, зөв тэнцвэржүүлэх,
- Орон нутгийн бизнесийн хөгжил, хөрөнгө оруулалтын уур амьсгалыг сайжруулахад сумын төр, захиргааны байгууллагаас гүйцэтгэх үүргийг тодорхой болгох,
- Эдийн засгийн ололт, бий болсон өсөлтийг тогтворжуулахад төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Стратеги төлөвлөлтийг олон нийтийг хамарсан бүтээлч үйл ажиллагааны хэлбэрээр сумын түвшинд зохион байгуулж зангидах,
- Одоо байгаа бизнесийг дэмжих, орон нутагтаа тогтоон барих асуудлыг шинэ бизнес бий болгохтой эн тэнцүү авч үзэх,
- Гадаад эх үүсвэр, хүчин зүйлд дулдуйдахыг эрмэлзэхээс илүү дотоод нөөц боломжоо энэ чиглэлд дайчлахад анхаарах,
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийг сумын эдийн засгийн хөгжлийн асуудлаар бодлого, стратегийг хэрэгжүүлэх арга хэрэглүүр болгон ашиглах,

Б. Арга зүйн асуудлууд. Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах ажлыг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөрөөс Дэлхийн Банктай хамтран боловсруулж Албани, Косово зэрэг орны хэд хэдэн хотын эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулахад хэрэглэгдэж баталгаажсан арга зүйгээр гүйцэтгэлээ. Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах үйл ажиллагааг процессийн хэмжээнд зөв зохион байгуулахад нэн зохимжтой, эмх цэгцтэйгээс гадна бизнесийн орчинг бодлого, зорилготой сайжруулахад чиглэгдсэн алсын хараа, зорилго, зорилт, түүнчлэн төслүүдийг дунд хугацааны баримжаатайгаар олон нийтийн оролцоо, харилцан ойлголцолд тулгуурлан боловсруулахад тохиромжтой хэмээн энэхүү арга зүйг сонгосон болно.

Орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, идэвхжүүлэх үйл ажиллагааг стратеги боловсруулах арга зүйн хүрээнд хамтруулан хэрэгжүүллээ. Юуны өмнө бизнес хөгжихөд ахиц өөрчлөлт авчрах тэнцвэржсэн орчин бүрдүүлэх замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгоход сумынхны хүчин чармайлтыг байгаа нөөц боломжтой нь уялдуулан зохицуулах асуудал стратеги боловсруулах арга зүйн үндэслэл болсон юм.


2.2. Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын ба зохицуулалтын арга хэмжээ

Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын зарчим нь сумын ЗДТГ, төслийн үндсэн багаас гадна олон нийт, оролцогчдыг стратеги боловсруулах үйл ажиллагаанд түншлэлийн журмаар зохион байгуулалттайгаар шууд оролцуулах боломжийг хангахад чиглэгдсэн болно.

Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээтэй холбогдсон арга хэмжээг хариуцсан бие даасан төлөөллийн бүтцийг сумын ИТХ, Засаг даргын шийдвэрээр томилж ажиллуулснаар иргэдийн оролцоог үндсэнд нь хангалаа.

Төлөвлөлтийн Комисс. Төлөвлөлтийн комиссын бүрэлдэхүүнийг Засаг даргын 2007 оны нэгдүгээр сар 24-ний өдрийн 6 тоот захирамжаар томилон ажиллуулсан билээ. Засаг даргаар ахлуулсан тус комисс стратеги боловсруулах ажлыг зохицуулалт, удирдамжаар хангах, ажлын явц, стратегийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийхтэй

СЭЗХ-ийн стратеги боловсруулахад оролцсон төлөөллийн бүтэц



холбоотой асуудлаар шийдвэр гаргахад гол үүрэг гүйцэтгэсэн юм. Сумын эдийн засаг-бизнесийн хөгжлийн асуудлаар зөвшилцөх, шийдвэр гаргахад оролцох мэдлэг туршлага, чин хүсэл зэргээр нь хүмүүсийг сонгож, төлөвлөлтийн комиссын бүрэлдэхүүнд оруулсан болно.

Сумын засаг дарга болон ИТХ-ын дарга, сумын үндсэн багийн гишүүдээс гадна комиссын удирдлагын дор байгуулагдсан ажлын хэсэг тус бүрээс 2-3 хүнийг бүрэлдэхүүнд нь оруулж энэ комиссыг байгуулсан юм.

Төлөвлөлтийн комисс нь стратеги боловсруулах үйл ажиллагааг зохицуулахаас гадна төрийн ба хувийн хэвшлийн байгууллагуудын идэвхтэй, чин эрмэлзэлтэй оролцоог хангах, тэдний дунд өргөн хүрээтэй ярилцлага, зөвшилцлийг олон хэлбэрээр зохион байгуулах, өрнүүлэхэд анхаарч ирлээ. Энэ комисс стратегийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт үнэлгээгээр хангах, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийн асуудлаар нэгдсэн шийдвэр гаргах чиглэлээр ДЕЛТА төсөл дууссаны дараа үргэлжүүлэн ажиллах юм.


Тариалан сумын Төлөвлөлтийн Комиссын бүрэлдэхүүн:

- | | |
|---|--|
| 1. Д.Батжаргал Засаг даргын орлогч, сумын ИТХ-ын төлөөлөгч | 7. Ж.Ганбат Хөвсгөлдүүлга ХХК-ийн захирал |
| 2. С.Мөнхөө Татварын улсын байцаагч, сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга | 8. Л.Гэрэлхүү Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч, сумын ИТХ-ын төлөөлөгч |
| 3. С.Ламжав Батзол ХХК-ийн захирал | 9. Ч.Сарангуяа Нийгмийн ажилтан |
| 4. С.Бадамсүрэн Мал эмнэлэг, үржлийн албаны байцаагч | 10. Э.Зоригт Соёлын төвийн ажилтан, сумын ардчилсан социалист залуучуудын холбооны тэргүүн |
| 5. С.Эрдэнэдалай Сумын газрын даамал, агрономч | 11. Д.Оюунчимэг Орон нутгийн идэвхтэн сурвалжлагч |
| 6. Б.Пүрэвдорж Алтандуулга ХК-ийн нягтлан бодогч | 12. Ё.Батзориг Бизнес хөгжлийн албаны менежер |

Төслийн үндсэн баг. СЭЗХ-ийн стратеги боловсруулах бүтцийн цөм болж ажилласан төслийн үндсэн баг нь СЭЗХ-ийн стратеги боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд цаашдаа хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, засвар өөрчлөлт хийх үндэслэл санал боловсруулах асуудлыг хариуцан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах болно. Төслийн үндсэн баг нь төсөл хэрэгжүүлэгч ба гүйцэтгэгч байгууллагууд, түншүүд болон эдийн засгийн хөгжлийн асуудлыг сонирхон оролцох хүсэлтэй байгууллагуудтай хамтран ажиллахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн болно.

Төслийн үндсэн багийг Засаг даргын захирамжаар дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллууллаа.

1. **Д.Батжаргал**
Төслийн үндсэн багийн ахлагч,
Засаг даргын орлогч
2. **Ц.Хөвсгөлдалай**
Засаг дарга
3. **С.Мөнхөө**
Татварын улсын байцаагч,
эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга
4. **С.Ламзав**
«Батзол» ХХК-ийн захирал



Төслийн үндсэн багийн бүрэлдэхүүнд ня-бо, эдийн засагч, худалдааны мэргэжилтэн, инженер зэрэг төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг сонгож оруулсан нь стратегийг иж бүрэн боловсруулахад чухал ач холбогдолтой болов.

Ажлын хэсэг. Сумын хөгжлийн стратеги боловсруулахад зөвлөх үүрэгтэй ажлын 5 хэсэг байгуулж төлөвлөлтийн комиссын шууд удирдлагын дор ажиллуулав. Ажлын хэсэг бүр янз бүрийн бүлгийн төлөөллийг оролцуулсан 5-аас дээш гишүүнтэй, дотроо ИТХ-аас 2-оос доошгүй хүнийг төрийн удирдлагын ажлын хэсэгт заавал оруулах зарчим баримталсан бөгөөд төслийн үндсэн багийн нэг гишүүн ажлын хэсгийн ахлагчаар ажиллав. Ажлын хэсэг байгуулсан гол зорилго нь олон нийтийн оролцоог төлөөллийн журмаар хангах боломжийг өргөжүүлэх явдал байлаа. Ийнхүү ажлын хэсгүүд олон нийтийг ДЕЛТА төслийн суман дахь баг, бүтцүүдтэй холбох чухал үүргийг гүйцэтгэлээ.

Төрийн удирдлагын ажлын хэсэг:

1. **Ц.Хөвсгөлдалай**
Сумын Засаг дарга, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч
2. **Д.Батжаргал**
Засаг даргын орлогч, сумын ИТХ-ын төлөөлөгч
3. **Л.Лхагвасүрэн**
ЗДТГ-ын дарга, сумын ИТХ-ын төлөөлөгч
4. **Ц.Түвшинбаяр**
ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга



5. **Д.Бадамням**
Нийгмийн даатгалын байцаагч,
сумын ИТХ-ын төлөөлөгч
6. **С.Бадамсүрэн**
Мал эмнэлэг, үржлийн албаны
байцаагч
7. **С.Эрдэнэдалай**
Сумын газрын даамал, агрономч
8. **Б.Жамбалдорж**
«Мандал» багийн засаг дарга
9. **Ж.Шаравдаваа**
«Баянхошуу» багийн засаг дарга
10. **Л.Нямсүрэн**
«Сэлэнгэ» багийн засаг дарга
11. **Б.Данзан**
«Тавантолгой» багийн засаг дарга
12. **Д.Бадрах**
«Давааны ар» багийн засаг дарга
13. **Х.Чулуун**
«Ар тархи» багийн засаг дарга

Бизнесийн төлөөллийн ажлын хэсэг:

1. **Ц.Цэвэлмаа**
«Сант жаргалант» ХХК-ийн нягтлан
бодогч
2. **Ж.Ганбат**
«Хөвсгөлдүүлга» ХХК-ийн захирал
3. **Д.Баярмаа**
«Хоёр богд» ХХК-ийн менежер
4. **Я.Оюунтуяа**
«Нямтуяа» нөхөрлөлийн эзэн
5. **Г.Доржпүрэв**
«Алтандуулга» ХК-ийн захирал
6. **Б.Пүрэвдорж**
«Алтандуулга» ХК-ийн нягтлан
бодогч
7. **С.Ламжав**
«Батзол» ХХК-ийн захирал
8. **Г.Оюунбилэг**
«Батзол» ХХК-ийн нягтлан бодогч

**Төсөвт байгууллагын ажлын хэсэг:**

1. **Л.Гэрэлхүү**
Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч
2. **Ч.Сарантуяа**
Нийгмийн ажилтан
3. **Х.Хишигжаргал**
Сумын цэцэрлэгийн эрхлэгч
4. **Б.Намганжав**
Нийтийн ахуй үйлчилгээний
төвийн захирал
5. **Д.Тэмүүл**
Байгаль орчны хяналтын байцаагч
6. **М. Байгальмаа**
Холбооны салбарын эрхлэгч

Малчдын төлөөллийн ажлын хэсэг:

1. **Б.Баянмөнх**
«Давааны ар» багийн малчин
2. **С.Алтангэрэл**
«Тавантолгой» багийн малчин
3. **Ж.Гантөмөр**
«Сэлэнгэ» багийн малчин
4. **Д.Цогоо**
«Баянхошуу» багийн малчин
5. **Д.Өлзийбаяр**
«Баянхошуу» багийн малчин
6. **Б.Эрдэнэчулуун**
«Тавантолгой» багийн малчин

Олон нийтийн төлөөллийн ажлын хэсэг:**1. С.Мөнхөө**

Татварын улсын байцаагч,
эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга

2. Ё.Батзориг

Бизнес хөгжлийн албаны менежер

3. Ё.Алтансүвд

АДРА төслийн ажилтан

4. П.Батмөнх

Сумын ахмадын холбооны дарга

5. Д.Оюунчимэг

Орон нутгийн идэвхтэн
сурвалжлагч

6. Г.Даваасүрэн

Хийдийн ловон лам

**2.3. Олон нийтийн оролцоо ба зөвшилцөл**

Сумын эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх олон нийт хүлээн зөвшөөрсөн, хэрэгжих боломжтой чиглэлүүдийг үзэл баримтлал сайтай, хэтийн баримжаатай, чанартай боловсруулах явдал сумын төр, захиргааны хувьд нэлээд тулгамдсан асуудал байсаар ирсэн билээ. Гэхдээ хөгжлийн стратеги ямар арга зүйгээр боловсруулахаа бүрэн гүйцэд төсөөлж чадаагүй, сумынхаа иргэд, байгууллагуудыг оролцуулах арга замаа үндэслэлтэй төлөвлөөгүй явж ирсэн тал байсныг ил тод хэлэх нь зүйтэй. Сумын эдийн засгийн хөгжлийн асуудлыг дан ганц захиргааны үүрэг, хариуцах ажил мэтээр ойлгодог явдал олон нийтийн дунд түгээмэл байсны дээр тэд өөрсдөө энэ үйл ажиллагаанд оролцож, хувь нэмэр оруулах иргэний үүргээ төдийлэн сайн ухаараагүй явсан тал ч бий.



Сумынхаа хөгжлийн үйл явцад хувь нэмрээ оруулах иргэний мэдлэг ойлголтыг батжуулах, чин эрмэлзлийг дэмжихэд төслийн эхнээс анхаарч зохих арга хэмжээ авч ирлээ. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн эхний шатны арга хэмжээ болох бизнес орчны судалгаа, СВОТ шинжилгээ нь иргэд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн төлөөллийг хангалттай хэмжээнд хамарч чадсан юм. Түүнчлэн олон нийтэд ойлголт өгөх, оролцоог өрнүүлэх арга хэмжээг уулзалт, ярилцлага, багийн иргэдийн хурал зэрэг арга хэмжээний үед таниулан сурталчлах, мэдээлэл гаргах, хэвлэл

мэдээллийн хэрэгслээр дамжуулах зэргээр хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнд сумынхаа иргэдийн дийлэнхи олонхид тодорхой мэдээлэл хүргэсэн нь төслийн ажил анхнаасаа оролцоог сайтар хангаж, олон нийтийг идэвхжүүлж чадсаныг гэрчилнэ.

Сумынхаа ЭЗХ-ийн стратеги боловсруулахад төр захиргаа, бизнес эрхлэгчид, төрийн үйлчилгээний болон олон нийт, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, хувь хүмүүс зэрэг нийтдээ 50 шахам хүн албан үүргийнхээ дагуу болон төлөөллийн журмаар шууд оролцов. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажил, арга хэмжээнд аль болох олон байгууллага, хүнийг оролцуулахыг байнга хичээж ажилласны үр дүнд хүмүүсийн сэтгэлгээнд томоохон өөрчлөлт орж, төсөл, түүний үр дүнг жинхэнэ «өмчлөгчид» болохоо ойлгох, мэдрэх чухал нөхцлийг бүрдүүлж чадсан гэж үзэж байна.

2.4. Бизнесийн орчны судалгаа

Бизнесийн орчны судалгаа явуулах, түүний үр дүнг сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн олон жилийн статистик үзүүлэлтүүдээр баталгаажуулах нь сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшин, өрсөлдөх чадвар, хэтийн төлөв, тулгамдаж буй асуудлыг үндэслэл, баримжаа сайтай тодруулах хамгийн боломжтой арга хэрэгсэл юм.

Бизнесийн орчны судалгааны хүрээнд бизнесийн хөгжил, орон нутгийн бизнесийн орчны асуудлаар оролцогчдын санал бодол, үнэлэмжийг судлах санал асуулгыг таван бүлэгт хамаарах 41 асуултаар явуулснаас гадна сумын эдийн засгийн үндсэн статистик үзүүлэлтүүд болон бусад мэдээллийг сүүлийн 5-10 жилийг хамруулан цуглуулж, дүн шинжилгээ хийлээ. Бизнесийн орчны судалгааны дүнг SWOT шинжилгээ хийх, цаашилбал бизнес орчны талаар сумын ЭЗХ-ийн стратегид тусгагдах гол үндэслэл, дүгнэлтүүдийг томъёолох суурь материал болгон ашиглав.

Эдийн засгийн хөгжлийг дэмжих, бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэхэд сумын төр, захиргааны зүгээс эдүгээ гүйцэтгэж буй үүргийг хувийн хэвшлийнхний үнэлгээнд тулгуурлан тодорхойлсон явдал энэ судалгааны нэг чухал үр дүн болсон юм. Тухайлбал:

1. Орон нутгийн бизнес эрхлэгчдийн санал дүгнэлтийг ул суурьтай таньж ойлгоход шаардлагатай мэдээ, тоо материал, баримт мэдээл цуглуулах
2. Сумын эдийн засаг-нийгмийн амьдралд оршин буй давуу ба сул талууд, бизнесээ өргөжүүлэх, өсөлт бий болгох, хадгалахад бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлуудтай холбоо бүхий мэдээ баримт хуримтлуулах

3. Бизнесийн орчинг сайжруулах, боловсронгуй болгох шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тухай бүр нь мэдэрч ажиллахын тулд орон нутгийнхны үнэлэмж, санал бодлыг судлах зэрэг болно.

Энэ судалгааг бүх шатанд амжилттай зохион байгуулж явуулахад бид бүх талаар анхаарч ажилласныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сумынхаа бизнес эрхлэгчдийг судалгаанд өргөн хамруулсны дээр тэдний гаргасан санал зөвлөмжийг ЭЗХ-ийн стратегид тусгасан явдал орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх шаардлага, арга замын талаар нийтлэг ойлголтод хүрэхэд чухал түлхэц өгсөн юм. Ийм байдлаар сумын эдийн засгийн өсөлтөд жинтэй нөлөө үзүүлсээр ирсэн, цаашдаа ч энэ нөлөө нь улам өсөх бизнесийн бүлгүүдийн санал үнэлэмжийг сумынхаа ЭЗХ-ийн стратегид тусгах үндсэн мэдээллээр хангаж өгсөнд бизнес орчны судалгааны ач холбогдол оршиж байгаа гэж үзэж буй болно. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг тогтворжуулах, сумын ЭЗХ-ийн стратегийг байнга хянан сайжруулах урт хугацааны удирдамж болох талаасаа бизнесийн орчны судалгааны үр дүн, дүгнэлтүүд чухал ач холбогдолтой болов.

2.5. SWOT шинжилгээ

Бизнес орчны судалгааны дүнг задлан шинжлэх, сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох, бизнесийн орчныг сайжруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх стратегийн чиглэлүүдийг тогтоох зорилгоор SWOT шинжилгээг явууллаа. Сумын бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа гол асуудлуудыг тодорхойлж, эерэг болон сөргөөр илэрч болох бүх талууд, тэдгээрийн зохистой шийдлийг хослолоор зэрэгцүүлэн томъёолоход SWOT шинжилгээний зорилго, хандлага чиглэгдсэн болно. Ингэснээр эдийн засгийн хөгжлийн төсөөлөн буй зорилгодоо хүрэх хамгийн зохистой, хэрэгжих хувилбарыг сонгох болон сумын ЭЗХ-ийн стратегийг дээр дурдсан хандлагад тулгуурлан боловсруулах үндэслэлийг тодорхойлж чадлаа.

Давуу тал ба боломжийг өндөр үр дүнд хүрэх стратегийн ирээдүйн чиглэл гэдэг агуулгаар авч үзэн нягтлан тодруулахад SWOT шинжилгээ чухал хэрэглүүр болж өглөө. Үүний чацуу оршин буй сул тал ба саад бэрхшээлийг даван туулахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойллоо. Сумын эдийн засгийн хөгжил, бизнес орчны өнөөгийн байдлыг нарийвчлан үнэлэх, эдийн засгийн хөгжлийн стратегийн гол шийдлийг SWOT шинжилгээгээр тогтоолоо.

SWOT шинжилгээг хийхдээ бизнес орчны судалгаанаас гарсан дүгнэлтийг сумын олон нийтээр хэлэлцүүлсэн дүн, эдийн засгийн холбогдох судалгаанд илүүтэй

түшиглэсэн болно. Төрийн үйлчилгээ, бизнесийн хөгжлийн чиглэлээр СВОТ шинжилгээний матрицийн 4 элементийг тодорхойлсноор «Давуу тал-Боломж», «Давуу тал-Саад бэрхшээл», «Сул тал-Боломж», «Сул тал-Саад бэрхшээл»-ийн СВОТ хослолыг нарийвчлан шинжлэх боломж хангагдсан юм. Базаж хэлбэл, сумын ЭЗХ-ийн стратегийн алсын хараа, зорилго, зорилтыг томъёолж, төслүүдийг сонгоход СВОТ шинжилгээний дүн суурь мэдээлэл болж өглөө.

2.6. “Алсын хараа–зорилго–зорилт–хөтөлбөр–төсөл” матриц

Алсын хараа: Стратегийн алсын хараа нь сумын нийт иргэдийн чин эрмэлзэл, хэтийн хүсэл тэмүүллийг тусгахаас гадна хэтийн ирээдүйд хүрэх түвшингийн талаархи тэдний төсөөллийг илэрхийлж байгаа юм. Түүнчлэн стратегийн зорилго, зорилтод хүрэхэд олон нийтийг алсын хараа хөтөлж чадна. Нийгэм-эдийн засгийн ба бизнесийн хөгжил, эдийн засгийн чадавхи, байгалийн нөөц баялаг, бизнесийн дадлага туршлага, уламжлал, ёс заншил, язгуур урлаг зэрэг эдүгээ цагийн нөхцөл боломж, бодит байдал дээр тулгуурлан стратегийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлж өгөв.

Нөөц боломжоо аль чиглэлд түлхүү зориулах, үр ашигтай дайчлан ашиглахад сумын захиргаа, олон нийтэд хөтөч болдог алсын харааг сумын эдийн засаг-бизнесийн хөгжлийн үйл явц, стратегийн үндсэн бүрдэл хэсгүүдийг цогцоор хамарсан, дунд хугацаанд хүрэх үр дүнгийн баримжаа, чиглэлтэйгээр томъёолсон гэж үзэж байна.

Алсын хараа маань сумын эдийн засаг, байгаль орчин, ахуй соёл, түүхэн уламжлал дээр суурилсан болохыг нотлох онцлог нөхцөл байдлыг тодруулахыг оролдлоо. Алсын хараа уян хатан, стратегийг хэрэгжүүлэх явцад гарч болох өөрчлөлтөд нийцүүлэн хянан өөрчлөх, сайжруулах боломжтойгоор томъёологдсон болохыг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм.

Зорилго: Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги нь угаасаа орон зайн ба цаг хугацааны хэмжүүрээр тодорхойлогдох дэвшил, ахиц өөрчлөлт бий болгох тухай асуудал билээ. Хүрч болох дэвшил, хэрэгжүүлэн бий болгох өөрчлөлтийг урьдчилан төсөөлж, тодорхойлох үндсэн дээр стратегийнхээ үр дүн, өгөөжийг хэрхэн томъёолохоо шийдэх чиг баримжаа авахад сумынханд дэмжлэг үзүүлэх үүднээс стратегийн зорилго тодорхойлох асуудалд хандсан юм. Алсын хараандаа амжилттай хүрэхэд хөтлөн залах үндсэн чиглэлийг тодорхойлохоос зорилгоо томъёолох ажлаа эхлэсэн болно. Сумын эдийн засгийн хөгжлийн нийтлэг ба тусгай асуудлуудад тулгуурласан, стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг багтаасан

байх шаардлагыг тавьж ажиллалаа. Алсын хараа ба зорилтын амьд холбоог хангахуйцаар зорилгоо томъёолоход анхаарлаа.

Зорилт: Зорилгоор дамжин алсын хараанд хүрэх, түүнчлэн хөтөлбөр, төсөлтэй зорилгыг холбох чухал хэрэглүүр нь зорилт болсон юм. Стратеги болон тусгайлсан зорилго, төслийн хэрэгжилтийг хяналт үнэлгээ хийхэд ашиглах хүрэх түвшингийн үзүүлэлт, тоон хэмжигдэхүүнтэйгээр зорилтыг томъёолох зарчмыг баримтлалаа. Товчхон хэлэхэд, зорилтыг зорилгын шууд үргэлжлэл байхаар төсөөлж ажилласан болно. Сумын бизнес орчны судалгаа, СВОТ шинжилгээгээр тогтоогдсон давуу талаа бэхжүүлэх, сул талаа даван туулах, боломжийг зөв ашиглах, саад бэрхшээлийг үндэслэлтэй тооцож ажиллах боломжийг стратегийн зорилтууд сумынханд олгож байгаа юм.

Хөтөлбөр: Хамтад нь хэрэгжүүлснээр тодорхой зорилт хангагдах талаас нь харж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр нь төслүүдийг бүлэглэх замаар томъёолсон хэд хэдэн хөтөлбөрийг стратегид орууллаа. Өөрөөр хэлбэл, зорилтыг зорилгоос шууд салбарлуулан гаргахад төвөгтэй байсны учир хөтөлбөрийг ийнхүү завсрын шатлал маягтайгаар боловсруулсан юм. Цаашдаа төслүүдийг нэгтгэн бие даасан томоохон хөтөлбөр боловсруулах суурь материал болох учраас стратегийн хөтөлбөрт ийнхүү ач холбогдол өгсөн болно.

Төсөл: Уламжлалт аргачлалаар бол стратеги төлөвлөгөө боловсруулах ажил үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр үндсэндээ шувтардаг билээ. Харин үйл ажиллагааны төлөвлөгөөний оронд тодорхой хөтөлбөрөөс уламжлуулан харилцан холбоо бүхий төслүүдийг стратегидээ тусгасан нь бидний хэрэглэсэн арга зүйн шинэлэг хандлага боллоо. Ийнхүү төсөл нь «алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл» гэсэн гинжин холбооны төгсгөл хэсэг болж байгаа юм. Товч танилцуулгыг төсөл тус бүрээр боловсруулж стратегид тусгасан болно. Төслийн танилцуулгад товч тодорхойлолт, хүлээгдэж буй үр дүн, зорилтот бүлэг, төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид, боломжит хувь нэмэр оруулагчид, урьдчилсан боломж, зэхэц нөхцөл, эрсдэлтэй хүчин зүйлс, шаардагдах хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх хугацаа, үр дүнгийн тогтворжилтийн талаархи товч мэдээллийг багтаалаа.

Тодруулан хэлэхэд, төсөл сонгох, боловсруулах ажлыг хэд хэдэн шат дамжлагатайгаар хэрэгжүүлсэн болно. Олон нийтийн хэлэлцүүлэг, ажлын хэсгүүдийн саналыг төслийн үндсэн багийн хэмжээнд нэгтгэн боловсруулж гаргасан хувилбарыг Төлөвлөлтийн Комиссоор хэлэлцэн зохих засвар, нэмэлт өөрчлөлт оруулж төслүүдийг эцэслэн боловсрууллаа.

Тариалан сумын эдийн засгийн хөгжлийн стратегид нийтдээ 35 төсөл тусгагдсан болно.

Бизнесийн хөгжлийг дэмжих стратеги чиглэлцүд. Эдийн засгийн өсөлт бий болгох, сум орноо хөгжүүлэхэд нутгийн бизнесийн үүрэг онцгой чухал учраас бизнесийн хөгжлийг дэмжих стратеги чиглэлүүдийг оролцогчдын хамтаар тодорхойлж стратегид тусгаж өглөө. Нийтдээ 37 чиглэлийг товчилсон тодорхойлолттойгоор энэхүү стратегид оруулав. Төслийн үндсэн баг, ажлын хэсгүүд, Төлөвлөлтийн комиссын шугамаар болон олон нийттэй хийсэн уулзалт, зөвшилцөөнөөр дээрхи чиглэлүүдийг тогтоосон болно.

2.7. Хүлээгдэж буй үр дүн

Стратегийг хэрэгжүүлснээр олон талтай, тооны хувьд ч цөөнгүй чухал үр дүн гарна хэмээн төсөөлж байгаа бөгөөд хүлээгдэж буй зарим гол үр дүнг тодруулбал:

- Сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд сумаас оруулах хөрөнгө, хувь хандивыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгах асуудлыг шийдвэрлэхэд ИТХ, ЗДТГ-г чиглэл өгөх,
- Стратегийн дэд хэсгүүдийн хэрэгжилтийг хариуцсан алба, байгууллага, ажилтны үйл ажиллагааг зохицуулах чадавхи, боломжийг дээшлүүлэх,
- Стратегид тусгагдсан тэргүүлэх чиглэл төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран санхүүжүүлэх боломжийг өргөжүүлэх,
- ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд оролцох, хувь хандив оруулах сонирхол бүхий орон нутгийн, үндэсний, олон улсын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, хандивлагчдыг татах, тэдэнд хандах боломж сайжрах,
- Сумын эдийн засгийг хөгжүүлэх чадавхи, орон нутгийн нөөц боломж тодорхойлогдсон, ашиглалт, эргэлтэд зохих хэмжээгээр орсон байх,
- Бизнес, бизнес орчны холбогдолтой мэдээллийн сүлжээ бий болж төлөвших, бэхжих,
- Төрийн үйлчилгээний байгууллагын чадавхи дээшилж, үйлчилгээний чанар сайжрах,

2.8. Стратегийг хэрэгжүүлэх

ЭЗХ-ийн стратеги нь сумын төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдийн хувьд эдийн засаг-бизнесийн хөгжлийн бодлого, гол гогцоо асуудлуудаар чиглэл авах албан ёсны баримт бичиг мөн. Энэ агуулгаараа тухайн үеийн шаардлага, нөхцөл байдлаас хамаарч стратегийг байнга хянан өөрчилж, шинэчилж байх ёстой.

Тариалан сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэх ажил хоорондоо нягт уялдаа бүхий 4 үндсэн арга хэмжээгээр дамжин хэрэгжинэ.

- Санхүүгийн эх үүсвэрийг идэвхжүүлэх, санхүүжилт олох,
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх,
- Хяналт үнэлгээг хугацаатай төлөвлөн хэрэгжүүлэх,
- Хянан сайжруулах, нэмэлт өөрчлөлт хийх,

Стратеги хэрэгжих хугацаа сумын одоогийн ба дараачийн сонгуулиар томилогдох удирдлагын бүрэн эрхийн хугацаанаас урт байх учраас түүний хувь заяа нь шинэ удирдлага үйл ажиллагааны залгамж чанарыг хэр хадгалж, олон нийтийн оролцоог хэрхэн хангаснаас ихээхэн хамаарна.

Стратегиэ хэрэгжүүлэх гол этгээд болохын хувьд хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр олох, гаргах үүрэг хариуцлага сумын төр, захиргаанд ногдож байгааг бид ойлгож ажиллах ёстой. Ер нь стратегид шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах санал бэлтгэх, ИТХ-аар батлуулах асуудлыг сумын ЗДТГ хариуцах нь зүйтэй гэж үзэж буй болно. Өөрөөр хэлбэл, стратегийн болоод төслийн хэрэгжилтийг зохицуулах, стратегийг хянах, зохих нэмэлт өөрчлөлт оруулж байх асуудлыг Төлөвлөлтийн комисстой хамтран сумын ЗДТГ санаачилж, гаргасан шийдвэрийн биелэлтийг хариуцах юм. Санхүүгийн ба техник ажиллагааны туслалцаа дэмжлэг авах асуудлаар сумын захиргаа хандивлагчид, засгийн газар, олон улсын байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.

Стратегийн хэрэгжилтийн явц гүнзгийрэхийн хэрээр энэ үйл явцад оролцох олон нийтийн сонирхол, идэвх дээшлэх нь мэдээж. Иймээс оролцогчидтой хамтран стратегийн хэрэгжилтийн байдлыг байнга хянаж, амжилт ололт, алдаа дутагдлаа үнэлж байх нь шинээр дэвшигдэн гарч ирэх асуудлууд, шаардлагыг оновчтой тодорхойлон стратегийн хүрээнд шийдвэрлэх боломжийг хангаж өгнө. Төсөл маань угаасаа сумынхны өмч учраас хяналт үнэлгээг хамтран хэрэгжүүлж байх үүрэг сумын удирдлага, олон нийтэд оногдох юм. Төлөвлөлтийн комисс энэ ажилд чухал үүрэг гүйцэтгэх болно.

2.9. Стратеги хэрэгжүүлэх зохион байгуулалтын асуудлууд

Стратегийн хэрэгжилт, хяналт үнэлгээний асуудлыг хариуцсан Төлөвлөлтийн комисс ажиллаж байгаа тухай өмнө дурдсан билээ. Тус комисс жилдээ 1-2 удаа хуралдаж, стратегийн хэрэгжилтийн талаар төслийн үндсэн багийн ахлагчийн тайлан, хяналт үнэлгээний дүнг авч хэлэлцэж зохих шийдвэр гаргаж байх

юм. Түүнчлэн жилд нэг удаа, баримжаалбал арван хоёрдугаар сард стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж, стратегид оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ИТХ-д оруулах санал бэлтгэнэ. Комиссын бүрэлдэхүүн өөрчлөгдөж болох ч стратегийн хэрэгжилтийг бүх талаар дэмжих, хяналт үнэлгээ хийх ажил үүрэг нь хэвээр байх юм.

ЗДТГ нь стратегийн хэрэгжилтийг хангуулах асуудлыг шууд хариуцах ба дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

- Төлөвлөлтийн комиссын үйл ажиллагааг хэвийн явуулах захиргааны ба ажил явууллагад дэмжлэг үзүүлэх,
- Стратегид нэр зааж тусгагдсан болон хэрэгжилтийн бусад үе шатанд шинээр оролцогчдоос хариуцах үйл ажиллагааг зохицуулах,
- Стратегийн хэрэгжилтийг олон нийтэд байнга мэдээлж, тэдний санал зөвлөгөөг тусгах, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх шинэ арга хэлбэрүүдийг санаачилж нэвтрүүлэх
- Стратегийн хэрэгжилтийн явцад 2 жил тутамд нэг удаа хяналт үнэлгээ хийж, хэрэгжилт, тухайн үеийн шаардлага, нөхцөл байдалтай уялдуулан нэмэлт тодотгол хийх, ИТХ-аар батлуулах, бусад төсөл хөтөлбөрт тусгуулах

2.10. Стратегийн санхүүжилт


Улсын төсвөөс тодорхой хөрөнгө оруулалт авах талаар хөөцөлдөхийн чацуу орон нутгийн иргэд, нутгийн зөвлөл бизнесүүд, хандивлагчид, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудаас хөрөнгө оруулалт хийх явдлыг дээд зэргээр дэмжин ажиллаж, энэхүү стратегийг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудлыг хамтран шийдвэрлэх зорилт тавих юм. Орон нутгийнхнаас стратегид тусгагдсан арга хэмжээнд шууд хөрөнгө оруулах нь стратегийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх томоохон боломжийг хангана.



БҮЛЭГ 3

ТАРИАЛАН СУМЫН ТАНИЛЦУУЛГА

Газар нутаг, хүн амын байршлыг харгалзан Хөвсгөл аймгийн зарим жижиг сумдыг нэгтгэх замаар Тариалан сум 1931 онд 11 багтайгаар байгуулагджээ. Хөвсгөл аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого (2005-2020 он)-оор зүүн бүсийн буюу газар тариалангийн бүсийн төв болон хөгжих, хэрэв хошууны зохион байгуулалтад орвол хошууны төв болох чиглэлтэй.



3.1. Газар зүй, цаг уурын нөхцөл, байгалийн нөөц баялаг

Тариалан сумын нутаг бүхэлдээ ойт хээрийн бүсэд хамаарагдана. 343.1 мянган га нутаг дэвсгэртэй. Тус сум Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Их-Уул, Рашаант, Булган аймгийн Тэшиг, Хутаг-Өндөр, Баян-Агт сумдтай хил залгадаг. Сумын нутаг дэвсгэр ерөнхийдөө нам дор байрлалтай, далайн түвшнээс дээш 925-2050м өргөгдсөн байдаг.

Тариалан сум улсын нийслэлээс 537 км, Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос 165 км, эдийн засгийн «Хангайн бүс»-ийн төв Эрдэнэт хотоос 270 км зайд оршино. Ханган нийлүүлэх гол төв нь Улаанбаатар, Эрдэнэт хот бөгөөд гадаад орнуудтай харилцах хилийн шууд гарц байхгүй.

Ер нь үржил шим сайтай газраа махны үхэр үржүүлэх, улаан буудай, малын тэжээл үйлдвэрлэх зэрэг эрчимжсэн чиглэлээр ашиглах нийтлэг зорилтыг дэвшүүлж байгаа бөгөөд сумын ЭЗХ-ийн стратегид эдгээр асуудлууд тусгагдсан болно.

Сумын байгалийн үндсэн баялаг болох ойн сангийн нийт нөөц 18611.5 мян.шоо. метр. Тархалт болон нөөцийн хувьд шилмүүст мод бүх нөөцийн 92.2%, хус 5.7%-ийг эзэлдэг. Зэрлэг жимс жимсгэнэ, эмийн ба тэжээлийн ач холбогдол бүхий ашигт ургамлаар баялаг. Зөвхөн эмийн ургамлын тоо гэхэд 60 орчим зүйл бий. Ойгоос модыг боловсруулах ба түлшний чиглэлээр авч ашигладаг.

Сумын газрын нөөц, ангилал

| Газрын ангилал | Хэм. нэгж | Хэмжээ, га | Газрын нөөцөд эзлэх хувь |
|----------------------------------|-----------|------------|--------------------------|
| Нийт нутаг дэвсгэр | га | 343067 | 100.0 |
| ХАА–н эдэлбэр газар | га | 184930.2 | 53.9 |
| ▪ Бэлчээр | га | 158178.5 | 46.1 |
| ▪ Хадлан | га | 5370 | 1.6 |
| 1. Тариалангийн талбай | га | 21210 | 6.2 |
| ▪ Тариалдаг талбай | га | 6000 | 1.7 |
| ▪ Атаржсан газар | га | 4506 | 1.3 |
| 2. Ойн нөөц | га | 163298 | 47.6 |
| 3. Усны эдэлбэр газар | га | 811 | 0.2 |
| 4. Зам, шугам сүлжээний газар | га | 387.4 | 0.1 |
| 5. Хот, суурингийн эдэлбэр газар | га | 407.4 | 0.1 |


Цаг уур, хур тунадас. Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын жилийн дундаж температур -0.8 хэм, зуны дулаан улиралд +16.5 хэм, өвлийн хүйтэнд -20.2 хэм, дээд тал нь зундаа +34 хэм, дүн өвлөөр -38 хэм хүрч хүйтэрнэ. Жилийн дундаж тундас 296 мм, хуртай жил 440 мм хүрэх ба гантай жил хур тунадас доод хэмжээндээ буюу дунджаар 140 мм орчим байдаг. Агаарын температур ба хур тунадасны хэмжээ улирал, сараар ихээхэн хэлбэлзэнэ.

3.2. Эдийн засгийн үндсэн ба туслах салбар


Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих явцад төрийн өмчид байсан газар тариалан, боловсруулах үйлдвэрийн суурин дээр хувийн өмч бүхий жижиг дунд үйлдвэрүүд шинээр үүсэв. Худалдаа, үйлчилгээний чиглэлийн олон тооны жижиг бизнес эрхлэгчид шинээр төрөн гарлаа. Боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн өмчийн салбарууд зах зээлд шилжих эхэн үед хүндрэлтэй байснаа сүүлийн жилүүдэд сэргэж эхэлж байна. Энэ бүх өөрчлөлт сумын дотоодын нийт бүтээгдэхүүний бүтэцэд тусгалаа олж байна. Одоохондоо сумын эдийн засгийн үндсэн салбар болох мал аж ахуйн эзлэх хувийн жин нэмэгдэж, газар тариалангийн салбарынх буурах хандлагатай байна. Харин тус суманд өмнө нь байсан гурил, тэжээлийн үйлдвэр, архи, спиртийн үйлдвэрийг сэргээн ажиллуулсны үр дүнд сумын дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах үйлдвэрийн эзлэх хувийн жин сүүлийн хэдэн жилд тогтвортой өсч иржээ.

Хэдийгээр сумын эдийн засгийн дотоод бүтэц өөрчлөгдөж байгаа боловч 2001 онтой харьцуулбал газар тариалангаас бусад салбарт бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Дотоодын нийт бүтээгдэхүүний бүтэц, %



Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, 2001=100%



тогтвортой өсчээ. Үүний дотор боловсруулах үйлдвэр, холбоо, тээвэр, мал аж ахуйн салбарын өсөлтийн хурдац илүү байна. Газар тариалангийн салбар сүүлийн 5-6 жилд тохиолдсон ган гандалт, цаг агаарын хатуу ширүүн цохилтод өртсөн хэдий ч сэргэх хандлага ажиглагдаж байна. Гэхдээ 2001 оны хэмжээнд хүртэл багагүй хугацаа шаардагдах төлөвтэй.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт

| Бүтээгдэхүүний нэр төрөл | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|--------------------------|--------|--------|--------|--------|--------|--------|
| 1 Үр тариа, тн | 5867.5 | 4753.3 | 4870.1 | 6080.4 | 5058 | 3196.6 |
| 2 Төмс, тн | 181.9 | 122 | 106 | 770 | 615.0 | 459.0 |
| 3 Хүнсний ногоо, тн | 152 | 140 | 228 | 191 | 192.5 | 88.9 |
| 4 Хадлан, тн | 12000 | 12000 | 12375 | 12585 | 12300 | 14114 |
| 5 Мах, тн | 410 | 358 | 584.5 | 728 | 976.5 | 998.6 |
| 6 Сүү, мян. литр | 312.7 | 330.2 | 286.1 | 330.5 | 439.6 | 512.0 |
| 7 Ямааны ноолуур, тн | 4.9 | 6.1 | 8.4 | 7.9 | 9.6 | 11.2 |
| 8 Богийн арьс, ширхэг | 8420 | 8400 | 12360 | 8122 | 9426 | 10046 |
| 9 Бодын шир, ширхэг | 1988 | 1910 | 2667 | 1551 | 1601 | 1746 |
| 10 Гурил, тн | 250 | 280 | 259.9 | 228.9 | 310 | 356 |
| 11 Тоосго, ширхэг | 40000 | 40000 | 30000 | 40000 | 40000 | 2000 |
| 12 Шохой, тн | 4000 | 5000 | 5000 | 6000 | 8000 | 10000 |
| 13 Архи, л | 3522 | 4920 | 5009.5 | 5176 | 5007.5 | 9751 |
| 14 Спирт, л | | | | 2100 | 7074 | 12700 |

Бизнесийн нэгжийн тооны өсөлт

| Бизнес эрхлэгчдийн төрөл | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|------------------------------|------|------|------|------|------|------|
| 1. Аж ахуйн нэгж | 24 | 28 | 33 | 37 | 37 | 39 |
| • Хувьцаат компани | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| • ХХК | 8 | 9 | 11 | 12 | 12 | 13 |
| • Хоршоо | 4 | 5 | 7 | 8 | 8 | 8 |
| • Нөхөрлөл | 9 | 10 | 11 | 13 | 13 | 14 |
| • ХЭАА | 1 | | | | | |
| • ХӨҮҮГ | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| 2. Малчин өрх | 799 | 817 | 773 | 729 | 710 | 699 |
| 3. Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 135 | 129 | 130 | 128 | 134 | 156 |
| Бизнесийн нэгжийн тоо | 984 | 1002 | 969 | 931 | 918 | 933 |

Ер нь байгаль цаг агаарын нөхцөлдөө зохицсон, уламжлалт үндсэн салбар мал аж ахуй, газар тариалангийн салбарт тулгуурлах нь орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх гол гарц гэж манай сумын олон нийт үздэг юм.

2007 оны 6-р сарын байдлаар сумын хэмжээнд аж ахуйн 39 нэгж, 97 хувиараа бизнес эрхлэгч, 699 малчин өрх бизнесийн үйл ажиллагаанд явуулж байна.

3.3. Хүн ам зүй, хүний нөөц, чадавхи

Тариалан сум хүн амын тоогоор аймаг дотроо тэргүүлдэг. Тус сум 2006 оны байдлаар нийт 1436 өрх, 5964 хүн амтай. Боржигин, гөрөөчин, долоон гөрөөчин, олхонууд, хариад, хар сүрэгтэн, хар халбагад, хонгор хүүхэн, цоохорууд, цэмцгэд, шандас, шаргадуул, шовхнор, эрхий мэргэн гэхчилэн олон овог амьдардаг. Нийт хүн амын 2985 нь эрэгтэй, 2979 нь эмэгтэй. Хөдөлмөрийн насны хүн амын 63.9% нь ямар нэгэн ажил эрхэлж байна.

| Он | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|-------------------------------|------|------|------|------|------|------|
| Нийт хүн ам | 6030 | 6162 | 6144 | 6011 | 5936 | 5964 |
| Эдийн засгийн идэвхтэй хүн ам | 2713 | 2702 | 2842 | 2547 | 2503 | 2964 |
| Ажиллагсад | 2635 | 2654 | 2788 | 2439 | 2421 | 2427 |

Өнгөрсөн 6 жилийн байдлаар сумын хүн амын өсөлт харьцангуй тогтвортой байгаа бөгөөд энэ нь суурьшил хэвийн болж, дэд бүтэц, эдийн засгийн харьцангуй таатай орчин бүрдсэний улмаас хүн амын шилжилт хөдөлгөөн багасаж байгаагаар тайлбарлагдана.

Амьжиргааны түвшний хувьд, 2006 оны байдлаар хүн амын 13.3% нь чинээлэг, 60.4% нь бага, дунд орлоготой, 26.4% нь ядуу, нэн ядуу гэсэн ангилалд багтаж байна. Тус суманд ядуу өрх 192, нэн ядуу өрх 189 байна.


Сүүлийн жилүүдэд ядуу, нэн ядуу өрх, хүний хувийн жин буурч, хүн амын амьжиргааны байдал сайжирч байгаа хандлага нь сумын хөгжлийн чухал ололтын нэг юм. Гэвч амьжиргааны өсөлтийн хурдцыг нэмэгдүүлэх, иргэдийн хүлээлтийг хангах бололцоо нөхцлийг бүрдүүлэх явдал нэн тэргүүний зорилт болж байна.


3.4. Нутгийн удирдлагын зохион байгуулалт, үйлчилгээ

Сумын өөрөө удирдах ёсны байгууллага - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нийт иргэдээ төлөөлсөн 20 гишүүнтэй. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хурлын чөлөөт цагт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх ИТХ-ын тэргүүлэгчид, ИТХТ-ийн даргыг томилох ба захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх сумын засаг даргад нэр дэвшүүлнэ. Түүнээс гадна багийн Иргэдийн Нийтийн Хурал багийн засаг даргыг сонгох бөгөөд багийн засаг дарга нь засаг даргын тамгын газрын бүрэлдэхүүнд орж ажиллана.

Засаг захиргааны дотоод зохион байгуулалтын хувьд Тариалан сум 6 багаас бүрдэнэ.

Тариалан сумын нутгийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц





Багийн эдийн засгийн үзүүлэлт

| | Өрхийн тоо | Хүн амын тоо | Малын тоо | Тариалангийн талбай, га | Сумын төвөөс зай |
|--------------|------------|--------------|-----------|-------------------------|------------------|
| Ар тархи | 138 | 575 | 16430 | 3969 | 65 |
| Баянхушуу | 167 | 706 | 30972 | 6453 | 20 |
| Давааны ар | 72 | 301 | 11031 | | 68 |
| Мандал | 743 | 3051 | 25182 | | |
| Сэлэнгэ | 120 | 504 | 23422 | 128 | 25 |
| Таван толгой | 206 | 827 | 29680 | 10660 | 10 |
| Сумын дүн | 1446 | 5964 | 136717 | 21210 | |

Тариалан сумын орон нутгийн төсөв 2001 онд 48.4 сая төгрөг байснаа 2005 онд 59.7 сая болж нэмэгдсэн байна. Харин үндэсний эдийн засгийн чадавхи сайжирч буй үйл явцын үр дүнд 2006 онд 73.5 сая төгрөгт хүрч нэг жилийн дотор огцом өсчээ. Сумын төсөв дэх орон нутгийн орлого дүнгээрээ ийнхүү өсөх хандлагатай ч орон нутгийн төсвийн зарлагад эзлэх хувийн жин нь буурч байгаа юм.

Сумын төсвийн орлого, зарлага, мян. төг

| Үзүүлэлтүүд | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|--|---------|---------|---------|---------|---------|---------|
| Орон нутгийн төсвийн орлого | 44185.9 | 71996.3 | 49531.3 | 44097.6 | 42153.8 | 44300.1 |
| • Хүн амын орлогын албан татвар | 18203.2 | 21480 | 19000.9 | 11875.8 | 14073.6 | 17634.3 |
| • Бууны албан татвар | 554.1 | 536 | 583.5 | 538 | 538 | 446 |
| • Ойн гоожин | 6006.6 | 6638.3 | 8738 | 7568.3 | 11697.4 | 9072.1 |
| • Газрын төлбөр | 9030.4 | 11538.9 | 11886 | 10729.1 | 10608.6 | 10667.4 |
| • Ус ашигласны төлбөр | 60 | 64.7 | 60 | 182.1 | 77.3 | 112.6 |
| • Хүү торгууль | 881.9 | 1722.9 | 1001.5 | 1061.5 | 1054.5 | 1095.2 |
| • Бусад орлого | 9449.7 | 30015.5 | 8261.4 | 12142.8 | 4104.4 | 5272.5 |
| Орон нутгийн төсвийн зарлага | 48378.7 | 55287.9 | 46520.8 | 56608.3 | 59695.1 | 73461.0 |
| • Цалин | 18250.6 | 20645.2 | 19873.3 | 24225.8 | 27294.6 | 33380.1 |
| • НДШ, ЭМД | 3956.2 | 4751.3 | 5246.8 | 6395.5 | 7205.8 | 8812.3 |
| • Гэрэл цахилгаан | 186 | 267.6 | 239.4 | 346.3 | 379.5 | 264.3 |
| • Тээвэр шатахуун | 3950 | 4591.3 | 5610.3 | 7007.3 | 9038.6 | 10379.1 |
| • Шуудан холбоо | 456 | 956 | 982.9 | 1714.6 | 1921.2 | 1519.2 |
| • Албан томилолт | 1203.5 | 2655.4 | 1386.4 | 1283.3 | 1019 | 1397.3 |
| • Бусад зардал | 20376.4 | 21421.1 | 13181.7 | 15635.5 | 12836.4 | 17708.7 |
| Орон нутгийн төсвийн зарлагад улсын төсвийн санхүүжилтийн эзлэх хувь | 8.7 | | | 22.1 | 29.4 | 39.7 |

3.5. Дотоод, гадаад харилцаа

Тариалан сумын төр, захиргаа, төрийн үйлчилгээний байгууллага, бизнес эрхлэгчид аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газар түүний харьяа газар хэлтэс, мэргэжлийн байгууллагууд болон Улаанбаатар хотын аж ахуйн нэгж, байгууллага, бизнесүүдтэй өөр өөрийн чиглэлээр байнгын ажил төрлийн харилцаатай байдаг. Газар тариалан, боловсруулах үйлдвэр эрхэлдэг Алтандуулга, Батзол, Тариалан спирт, Сант Жаргалант зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд МҮХАҮТ-ийн гишүүн байгууллага болж, Алтандуулга ХК Канадын «Жон Деер» компанитай, Батзол ХХК ОХУ-ын Эрхүү мужийн «Ирагромаш» байгууллагатай харилцаа тогтоон газар тариалангийн үйлдвэрлэлд нөөц хэмнэх, хөрс хамгаалах технологи нэвтрүүлэн ажиллаж байна.

Малчид, хувиараа тариалан болон жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хувьд бизнесийн чиглэлээр гадагш тогтоосон тогтвортой холбоо харилцаа бага. Сумын захиргаанаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Цахар Баруун гарын Дунд хошуутай эдийн засаг, соёл, боловсрол, эрүүл мэнд, худалдаа, бизнесийн талаар хамтран ажиллах гэрээ байгуулж ажлаа эхлээд байгаа. Сумын захиргаанаас аймгийн төв, Улаанбаатар хотод оршин суугаа нутгийн иргэдтэй байнгын холбоо харилцаа тогтоож, нутгийн зөвлөл байгуулан ажиллаж байгаа нь иргэдийн хоорондын харилцааны чухал хэлбэр болдог.




БҮЛЭГ 4

СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТОЙМ

4.1. Сумын эдийн засгийн хөгжлийн одоогийн байдал, хэтийн төлөв

Мал аж ахуй. 2006 оны эцэст сумын дүнгээр 137243 толгой мал, үүний дотор 26 тэмээ, 8287 адуу, 15550 үхэр, 54216 хонь, 59164 ямаа тоологджээ. Сумын хэмжээгээр нийт 699 малчин өрх, 1578 малчинтай, нийт малын 99.8% нь хувийн хэвшилд хамрагдаж байна.

Сүүлийн 6 жилийн малын тооны өсөлтийг үзвэл, 2003 онд бага зэрэг хорогдсоныг эс тооцвол ерөнхийдөө өсөх чиглэлтэй байна. Ямаа тогтвортой өсч, адуу буурах хандлагатай, хонь үхрийн тоо хэлбэлзэлтэй байв.



Малын тэжээл бэлтгэл, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажилд жил бүр ахиц дэвшил гарч байна. Сүүлийн 2 жилийн байдлаар жилдээ 12-14 мянган тн хадлан, 20-26 тн гар тэжээл бэлтгэж, 60 мянган га бэлчээрийн усан хангамжийг сайжруулжээ. Мал сүргийг эрүүлжүүлэх зорилгоор хувийн мал эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөхөд сумаас зохих анхаарал тавьж байна.

Мал аж ахуйг хөгжүүлэх талаар төлөвлөж буй хэтийн чиглэлийн тухайд үхэр сүргээ Сэлэнгэ, Ангус үүлдэрээр сайжруулж махны чиглэлээр эрчимжүүлэх, Хар тарлан үүлдрийг ашиглах, нутгийн үүлдэр, омгийн шилмэл хээлтүүлэгчээр хангах арга хэмжээ багтаж байна. Газар тариалан болон сумын төвийн зах зээлд түшиглэсэн эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахианы аж ахуй хөгжүүлэх, байгалийн бэлчээрийн даац, чадавхийг зөв ашиглах, малын тэжээл, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, малчдын үйлдвэрлэл, маркетинг, ахуйн дэд бүтцийг сайжруулах явдлыг гол чиглэл болгож байна.

Газар тариалан. Тариалан сумын эдийн засгийн үндсэн салбарын нэг нь уламжлалт газар тариалангийн үйлдвэрлэл юм. 1938 онд Алаг-Эрдэнэ сумын өвс хадах морин станцыг Тариалан суманд шилжүүлснээр үр тариа тариалж эхэлжээ. 1943 онд Тариалан сумын МТС-ыг сангийн аж ахуй болгож, үр тарианы үйлдвэрлэлийг голлон эрхлэх болж энэ үеэс тус сум газар тариаланг эрхлэн хөгжүүлэх болсон юм. Тариалан сум 21210 га эргэлтийн талбайтай, үүнээс сүүлийн жилүүдэд дунджаар 5800 орчим га-д тариалалт явуулж байна. Үүнээс үр тариа 5700 га, төмс 50-80 га, хүнсний ногоо 20-27 га-д тариалж, нэг га-аас дунджаар 9.5-10.2 цн үр тариа, 80 цн төмс авч байна. Газар тариалангийн үйлдвэрлэл дээр аж ахуйн 18 нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 24 ажилладаг. Газар тариалангийн томоохон аж ахуйн нэгжүүдэд Алтан дуулга ХК, Батзол, Хоёр богд, Ар тархи ХХК-ууд, Эрхүүдийн буудай ББН багтаж байна. Газар тариалангийн салбарт техникийн болон үрийн сортын шинэчлэл хийх, усалгаатай тариалан, цомтгосон технологи нэвтрүүлэх явдал хойшлуулшгүй зорилт болон тавигдаж байна.

Боловсруулах үйлдвэр. Тариалан сумын байгалийн баялаг, үндсэн үйлдвэрлэлийн чиглэлээс шалтгаалан үр тариа, мод боловсруулах чиглэлийн үйлдвэр голлон хөгжсөн. Гурил, тэжээлийн үйлдвэрүүд өөрийн суманд үйлдвэрлэсэн буудайг бүрэн боловсруулж, Хөвсгөл аймгийн бусад сумыг гурил, тэжээл, спиртээр хангах зорилготой ажиллаж байна.

Боловсруулах үйлдвэр эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд

| | Аж ахуйн нэгжийн нэр | Хариуцлагын хэлбэр | Үйлдвэрлэлийн чиглэл |
|---|----------------------|--------------------|--------------------------------|
| 1 | Алтан дуулга | ХК | Гурил |
| 2 | Батзол | ХХК | Гурил |
| 3 | Шанш | Хоршоо | Худалдаа, блок |
| 4 | Тариалан спирт | ХХК | Спирт |
| 5 | Сант жаргалант | ХХК | Архи |
| 6 | Хөвсгөл барилга | ЗБН | Зүсмэл материал, тоосго, шохой |
| 7 | Гурван бадрах | Хоршоо | Модон материал |
| 8 | Батшинэс | ББН | Зүсмэл материал |

Боловсруулах үйлдвэрийн хөгжлийн гол чиглэл нь бүх салбарт техникийн шинэчлэл хийх, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, барилгын материал, мал аж ахуй, газар тариалан, байгалийн нөөц баялагт түшиглэсэн, сумын дотоод хэрэгцээнд чиглэсэн боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх явдал гэж үзэж байна.

Худалдаа үйлчилгээ. Тариалан суманд худалдааны 40 орчим цэг, зоогийн 6 газар, нийтийн хоолны 7 цэг ажиллаж байна. Суман дахь худалдаа үйлчилгээний ажилд тус сумын аж ахуйн 11 нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч 39 иргэн оролцдог. Үйлчилгээний соёл, чанарын түвшинг дээшлүүлэх, үйл ажиллагааны орчинг сайжруулах, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь худалдаа үйлчилгээний чиглэлээр ойрын хугацаанд хэрэгжүүлбэл зохих гол зорилт болон тавигдаж байна. Ялангуяа сумын төвөөс алслагдсан малчдад үйлчилгээг ойртуулах, зам харилцааны нөхцлийг сайжруулах нь нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал болж байна.

4.2. Ажиллах хүчний чадавхи, хангамж, хүрэлцээ

Мал аж ахуйд сумын нийт ажиллагсдын дийлэнх хэсэг буюу 65%, худалдаа, үйлчилгээний салбарт 12.6%, газар тариаланд 10.5%, боловсролын салбарт 4.7% нь ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд газар тариалан, боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо буурч худалдаа, үйлчилгээ, мал аж ахуйд ажиллагсад өсч байгаа нь уг салбаруудын хөгжлийн явцтай холбоотой. Цаг агаарын хүндрэлийн


Ажиллагсдын тоо, салбараар

| Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчдын тоо | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|------|------|------|------|------|------|
| | 2635 | 2654 | 2788 | 2439 | 2421 | 2427 |

Үүнээс: үйлдвэрлэлийн салбараар

| | | | | | | | |
|----|----------------------|------|------|------|------|------|------|
| 1 | Мал аж ахуй | 1518 | 1451 | 1456 | 1437 | 1439 | 1578 |
| 2 | Газар тариалан | 515 | 590 | 510 | 391 | 390 | 254 |
| 3 | Боловсруулах үйлдвэр | 75 | 83 | 72 | 53 | 54 | 33 |
| 4 | Цахилгаан дулаан | 6 | 4 | 5 | 5 | 5 | 31 |
| 6 | Холбоо, тээвэр | 6 | 8 | 6 | 4 | 4 | 4 |
| 7 | Худалдаа үйлчилгээ | 286 | 291 | 300 | 307 | 310 | 307 |
| 8 | Төрийн байгууллага | 43 | 31 | 46 | 45 | 46 | 32 |
| 9 | Боловсрол | 118 | 120 | 120 | 110 | 110 | 113 |
| 10 | Эрүүл мэнд | 36 | 34 | 32 | 30 | 41 | 34 |
| 11 | Бусад | 32 | 42 | 241 | 57 | 22 | 41 |

улмаас малын тоо буурахад малчдын тоо буурч, харин мал сүрэг өсөхийн хэрээр малчдын тоо дагаж нэмэгдэх байдлаар өөрчлөгдөж байна. Дээрхи хандлага газар тариалан, түүнийг дагалдсан боловсруулах үйлдвэрт нэгэн адил харагдаж байна.



Ажиллагсдын боловсролын түвшин харьцангуй доогуур, 2006 оны байдлаар нийт ажиллагсдын 3.7% нь дээд, 6.1% нь тусгай дунд боловсролтой, 6,3% нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн мэргэжилтэй ажилчин, 84% нь мэргэжилгүй байна. Сүүлийн жилүүдэд дээд боловсролтой болон мэргэжилгүй хүний эзлэх хувийн жин өсч, мэргэжилтэй ажиллагчдын хувийн жин буурах хандлагатай байгаа нь цаашид мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд илүү анхаарал тавих шаардлагатайг харуулж байна.

Ажилгүйдлийн түвшин 2.3% байгаа нь аймгийн дундаж түвшингээс 1.3% доогуур бөгөөд ажилгүйдэл 2004 он хүртэл өсч, сүүлийн жилүүдэд буурах хандлагатай болжээ.

Хөдөлмөрийн насны ажилгүй хүмүүсийн дотор эмэгтэйчүүд 38.2%, мэргэжилгүй хүмүүс 87%-ийг эзэлж байна. Ажилгүйдлийн нэг шалтгаан нь мэргэжил боловсрол хангалтгүй байгаатай холбоотой болохыг судалгаа харуулж байна.

4.3. Дэд бүтэц, үйлчилгээ

Зам, тээвэр. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд гол нь аймгийн төв, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хоттой харилцдаг. Улаанбаатар хоттой Булган аймгийн төвөөр дамжин холбогдоно. Булган аймгаас Улаанбаатар хот хүртэл Эрдэнэт, Дархан хотоор дамжсан хатуу хучилттай замтай. Аймгийн төв болон зэргэлдээ сумууд, Булган аймагтай сайжруулсан шороон замаар холбогддог. Сумын төв, сумын дотоодод энгийн шороон замтай. Сумын нийт зам, ялангуяа багуудад хүрэх замын нөхцөл тааруу. Сумаас гадагш болон сумын доторхи ачаа, зорчигч тээврийн үйл ажиллагааг хувийн хэвшлийнхэн авто тээврийн хэрэгслээр гүйцэтгэдэг. Сумын төвийн зам, сумын төвөөс Мөрөн-Улаанбаатарын төв зам хүртэл хэсгийг хатуу хучилттай болгох, сумын төвөөс багууд хүрэх замын нөхцлийг сайжруулах, даваануудыг засах, гол горхи дээр гүүр тавих нь гадаад, дотоод тээврийг шуурхай болгож, сумын зах зээлийг хөгжүүлэхэд чухал хүчин зүйл болно.

Эрчим хүч. Тариалан сумын төв нь 1997 онд Эрдэнэт, Булганы чиглэлийн 35квт-ын өндөр хүчдэлийн шугамд холбогдсон, цахилгаан эрчим хүчний байнгын хангамжтай, сард дунджаар 120-150 мянган квт эрчим хүч дамжуулан авч, 60 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, 700 гаруй өрхөд борлуулалт хийдэг. Хөдөөгийн багуудад цахилгаан эрчим хүч хүрээгүй. Малчдын 35 хувь нь нар салхины эрчим хүчээр хангагдсан болно. Эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор ойрын хугацаанд сумын төв орчмын дулаан дамжуулах шугамын засвар хийх, багуудыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох, малчдыг нар салхины эрчим хүчээр бүрэн хангах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм.

Холбоо, мэдээлэл. Байнгын ажиллагаатай суурин холбоо, шуудангийн салбартай, 2004 онд шилэн кабель тавигдсан. Одоо аж ахуйн нэгж байгууллагын 37, айл өрх 171, нийт 208 телефон хэрэглэгчтэй. Суманд 4 сувгийн телевизийн нэвтрүүлэг цацаж, 10 сувгийн кабелийн телевиз 130-аад өрхөд үйлчилж байна. 2005 оноос сумын төвийг Скайтел, Мобикомын хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбож, 2007 оноос «Хөдөөгийн холбоо» төслөөр сумын төвийн ойролцоох малчин өрхүүдэд гар утас ашиглах техникийн боломжийг бий болгоод байна. Интернэтийн үйлчилгээ

нэвтрүүлэх техникийн боломж бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Цаашид холбоо, мэдээллийг сайжруулах, үүний тулд сумын төвд богино долгионы FM радио нэвтрүүлэг явуулах, малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах, бизнесийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ нэвтрүүлэх шаардлага байгаа.

Банк, санхүүгийн үйлчилгээ. Манай суманд ХААН банк, Монгол шуудан банкны салбарууд, «Хөгжил бадрах» банк бус санхүүгийн байгууллага байнгын, ХАС банк явуулын үйлчилгээ үзүүлж байна. 2006 онд олгосон нийтдээ 1.8 тэрбум төгрөгийн зээлийн 90 хувийг ХААН банк эзэлж байна. ХААН банк, Монгол шуудан банкууд онлайн сүлжээнд холбогдсон. Монгол даатгал, Түшиг даатгал зэрэг даатгалын байгууллагууд явуулын үйлчилгээ эрхэлдэг.

Усан хангамж. Сумын нутаг дэвсгэрт Сэлэнгэ мөрөн, 45 гол горхи, 4 нуур цөөрөм зэрэг байгалийн гадаргын усны эх үүсвэр байдаг. Мөн гүн өрмийн худаг 16, гар худаг 31, нийт 47 худагтай, бэлчээрийн 40 хувь нь усны эх үүсвэрээр хангагдсан. Тариалан сумын төвийн усан хангамжийн чанар, хүрэлцээ тааруу. Сумын төв болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, сумын төвд түгээж буй ундны усыг зөөлрүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байгаа.

Бохир ус. Сумын төв бохир ус зайлуулах системгүй. Үүнээс шалтгаалан хөрсний бохирдолт үүсч байгаа. Цаашид сумын төвийг бохир ус зайлуулах нэгдсэн системтэй болгох шаардлагатай гэж үздэг.

Дулаан хангамж. Сумын төв төвлөрсөн халаалттай бөгөөд нийт 29512 м3 талбайд дулаан түгээж, сумын бүх төсөвт газрууд, зарим орон сууц, аж ахуйн нэгжүүд халаалтын системд хамрагддаг. Сумын төвийн дулааны шугам сүлжээ ихэд хуучирч муудсан, цаашид өргөтгөх боломж муутай. Дулааны шугам сүлжээг засварлах, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх зорилт тулгарч байгаа.

Боловсролын үйлчилгээ. Ерөнхий боловсролын сургууль анх 1939 онд 2 багш, 3 ажилтан, 30 сурагчтай байгуулагдсан. 1953 онд бүрэн бус, 1956 онд бүрэн дунд сургууль болсон. Одоо тус сумын ерөнхий боловсролын сургуульд 1453 хүүхэд сурч, дотуур байранд 280 хүүхэд амьдарч, 60 гаруй багш, 40 гаруй ажилтан ажиллаж байна. Ерөнхий боловсролын 11 жилийн сургалтад бүрэн шилжиж, энэ оноос 12 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэл ажлыг хангаж байна. Шалтгаангүй сургууль завсардалт бүрэн зогсч, хамран сургалт 94.5 хувьд хүрчээ. Сургуулийн хичээлийн ба дотуур байрын хүрэлцээг сайжруулах, мэргэжлийн багш, сургалтын тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах зэрэг арга хэмжээг ойрын хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сургуулийн өмнөх боловсрол. Хүүхдийн цэцэрлэг 1954 онд хүмүүжүүлэгч 2 ажилтантайгаар байгуулагдсан. 1987 онд 120 хүүхдийг хүлээн авах хүчин чадалтай барилга ашиглалтанд оруулсан бөгөөд одоо 13 орон тоотойгоор ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын тогтолцоонд хамрагдвал зохих хүүхдийн 47.7 хувийг хамардаг. Хүн ам илүү төвлөрсөн 2-3 чиглэлд зуны түр цэцэрлэг ажиллуулах замаар сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдүүдийн сургуульд орох бэлтгэлийг хангаж байна. Цаашид цэцэрлэгийн байрыг өргөтгөх, тохижилтыг нь сайжруулах замаар сургуулийн өмнөх боловсрол олгох тогтолцоонд хүүхдүүдийн хамралтын хүрээг өргөтгөх зорилттой ажиллаж байна.

Эрцл мэндийн үйлчилгээ. 1937 онд 2 гэр 6 ортой бага эмчийн салбар байгуулагдсанаар сумын эрүүл мэндийн байгууллагын эхлэл тавигджээ. Одоо сумын хүн эмнэлгийн салбарт нэг их эмч, 32 ажилтан ажиллаж байна. Сумын хүн эмнэлгийн салбар түргэн тусламжийн машинтай, бүх багийн эмч нар мотоцикльтой болсон. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийг сайжруулах, багийн эмч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээг шат дараалалтайгаар явуулж байна. Цаашид эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх талаар хүн эмнэлгийн байрыг өргөтгөх, мэргэжлийн их эмч, эмнэлгийн ажилтан, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, багуудад эрүүл мэндийн төв, бага эмчийн салбар байгуулах, хүн амын эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг эрүүл мэндийн зарим төрлийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах хойшлуулшгүй зорилт тавигдаж байгаа юм.

Соёл, урлагийн үйлчилгээ. Тус сумын соёлын төв 1944 онд «Улаан гэр» нэртэйгээр байгуулагдаж, 1993 оноос Соёлын төв болж өргөжсөн ба одоо 6 орон тоотойгоор ажиллаж байна. Одоо суманд улсын тэргүүний уран сайханч 10, соёлын тэргүүний ажилтан 4 байна. Сумын засаг даргын захирамжаар түүх соёлын дурсгалт газар, эд өлгийн зүйлсийг хамгаалалтад авч, орон нутаг судлах музей, нийтийн номын санг тохижуулах, музейн үзмэрийн сан, номын фондыг баяжуулах, урлаг спортын наадам зохион байгуулах ажлыг хийж байна. Соёлын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах, номын санг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сайжруулах нь соёлын үйлчилгээний гол зорилт болж байна.

Цагдаагийн байгууллага. Ард иргэдийн амгалан тайван ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх нь төрийн нэг чухал үүрэг юм. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх сумын хөтөлбөр гаргаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, архидалт хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх сангууд, хууль эрх зүйн мэдээллийн танхмыг байгуулан, иргэдийн хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн архидан согтуурахтай тэмцэх төрөл бүрийн ажил зохиож, бод малыг им тамга, зүсмийн бүртгэлтэй болгох ажил хийж байна. Цагдаагийн хэсгийн ажлын байрыг шинэчлэн 2007 оноос цагдаагийн


хэсгийг тасаг болгон орон тоог нь нэмэгдүүлж, гурвалсан гэрээ байгуулан ажиллаж эхлэв. Цагдаагийн хамгаалалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ иргэдийн ухамсрыг дээшлүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжоор хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх, сумын төвийн гэрэлтүүлэг, замыг сайжруулах замаар иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх нь цаашид хэрэгжүүлбэл зохих зорилт гэж үзэж байна.

Биеийн тамир, спорт. Орон нутагт үндэсний болон их спортын төрлийг хөгжүүлэх бодлого чиглэл боловсруулан баталж, спортын бага наадмыг 2 жилд нэг удаа, уралдаан тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээг жил бүр төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж, спортод гоц авъяастай хүүхэд, залуучуудыг дэмжин урамшуулдаг журам гарган хэрэгжүүлж байна. Сургуулийн сурагчид, иргэдийн бие бялдрын үнэлгээ хийв. Дунд сургууль, соёлын төв дээр бие бялдар чийрэгж үлэлтийн танхим нээн ажиллуулж байна.

4.4. Зах зээл, маркетинг

Тариалан сумын бүтээгдэхүүний борлуулалт, ханган нийлүүлэх зах зээл нь сумын байршил, үйлдвэрлэлийн салбаруудын хөгжил, иргэдийн хэрэглээний шинж чанартай холбоотой. Хөдөө аж ахуйн түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүнээ сумын дотоод зах зээлд борлуулж, өргөн хэрэглээний барааг Улаанбаатар, Эрдэнэт хотоос авдаг.

Хүн ам олонтой, төвлөрсөн зах зээлээс хол байршилтай учир жижиг үйлдвэрлэл үйлчилгээний газруудын үйл ажиллагаа сумын дотоод хэрэгцээг хангахад гол



төлөв чиглэдэг. Харин томоохон аж ахуйн нэгжүүд газар тариалангийн анхдагч болон дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг ихэвчлэн аймгийн дотоод зах зээлд борлуулах чиглэлээр үйл двэрлэдэг. Цаашдаа төвлөрсөн зах зээлээс авч хэрэглэдэг сумын дотоод хэрэгцээний бараа бүтээгдэхүүнийг өөрийн үйлдвэрлэлээр хангах, үүний тулд чанартай үйлдвэрлэл үйлчилгээ бий болгох, үндэсний болон гадаад зах зээлд гарах зорилт тавьж байна.

Энэ зорилтыг хангахын тулд газар тариалан, гурил, спиртийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөх, техник, технологийг шинэчлэх, мал аж ахуйн шинэ салбаруудыг үүсгэн хөгжүүлэх, иргэдэд хүргэх худалдаа, үйлчилгээний нөхцлийг сайжруулах шаардлагатай байна

4.5. Суманд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд

Дэлхийн банкны «Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих» үндэсний хөтөлбөрийн «Тогтвортой амьжиргаа» төслийн бичил зээлийн үйлчилгээний хүрээнд сүүлийн 3 жилийн байдлаар нийт 23 иргэнд 6.5 сая төгрөгийн зээл олгосон, орон нутгийн санаачлагын сангаас жилд 4000 орчим долларын хөрөнгө оруулалт хийдэг.

Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр – бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор худаг гаргах, засварлах, хүн, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, нүүдлийн цэцэрлэг ажиллуулж малчдын хүүхдийн боловсролын өмнөх бэлтгэлийг хангах зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

ННФ-ын ДЕЛТА төсөл: «Сумын эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги» боловсруулах, бизнесийн хөгжлийн алба байгуулахад томоохон дэмжлэг үзүүлсний дээр орон нутгийн чадавхи бэхжүүлэх нэг төсөл шинээр нэмж хэрэгжүүлэх ажилд ороод байна.

«АДРА - Монгол төсөл». Тус бүр 10-аас доошгүй өрхтэй өөртөө туслах 10 бүлэг байгуулж, бүлэгт хамрагдсан өрхүүдийн эдийн засаг бизнесийн чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, сургалтад хамруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажил хийж байна.



БҮЛЭГ 5

СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

5.1. Бизнесийн орчны судалгааны дүн

Сумын ЗХ-ийн стратеги боловсруулах ажлын хүрээнд хэрэгжүүлэх чухал үйл ажиллагааны нэг нь бизнес орчны судалгаа байсан юм. Энэ судалгааг 2006 оны 8-9-р сард явууллаа. Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулахад шаардагдах суурь мэдээлэл хуримтлуулах зорилгоор явуулсан бөгөөд энэ явцад орон нутгийн эдийн засаг, бизнесийн хөгжлийн тухайн үеийн байдал, хэтийн төлвийг ойлгож мэдэх, ололттой талууд ба тулгамдаж буй асуудлын талаар бодитой мэдээлэл авах, судалгааны туршлага, дадлага эзэмшихэд нь орон нутгийнханд туслах зорилгыг давхар агуулж байлаа. Судалгааны дүнгээр бүрэн хэмжээний тайлан гаргаж олон нийтээр хэлэлцүүлж тэдний саналыг авсан болно.

Судалгаанд хамрагдагсад:

- Бизнесийн орчны судалгаанд бизнес эрхлэгч 120 аж ахуйн нэгж, иргэдийн 39.2%, 710 малчдын 5.1% нь хамрагдсан нь бүх бизнес эрхлэгчдийн 10% болж байгаа юм.

Бизнес эрхлэгчдийг судалгаанд хамруулсан байдал

| | Нийт тоо | Судалгаанд хамрагдсан | Хамрагдсан хувь |
|--------------------------------|----------|-----------------------|-----------------|
| 1 Жижиг, дунд бизнес эрхлэгчид | 120 | 47 | 39.2 |
| 2 Малчид | 710 | 36 | 5.1 |
| Бүгд | 830 | 83 | 10.0 |

- Эзэн 73, гүйцэтгэх захирал 1, менежер 4, бусад ажилтан 5 оролцлоо.
- Мал аж ахуй эрхэлдэг 49, газар тариалан эрхэлдэг 11, үйлдвэрлэл эрхэлдэг 9, худалдаа эрхлэгчид 22, үйлчилгээ эрхлэгчид 13 байлаа.
- Судалгаанд хамрагдагсдын бизнес эрхэлсэн хугацааг нь авч үзвэл 12.7% нь 5 хүртэл жил ажилласан, 55.6% нь 6-12 жил ажилласан, 31.7% нь 13-аас дэш жил ажилласан байлаа.
- Нийт бизнес эрхлэгчдийн 68 нь нэг, 11 нь 2, 2 нь 3, 2 нь 4 төрлийн бизнес эрхэлж байв.
- Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 86.7% нь 5 хүртэл, 14.1% нь 6-50, зөвхөн 1.3% нь 50-аас дээш тооны ажиллагсадтай байв.

Бизнесийн өргөжилт. Хөвсгөл аймгийн Тариалан суманд малчдын 88.6 хувь, бусад бизнес эрхлэгчдийн 78.3 хувь нь өөр өөрийн бизнесийг өргөжиж ирсэн хэмээн дүгнэсэн нь тус суманд бизнесийн үйл ажиллагаа ерөнхий хандлагаараа өргөжиж байгааг илэрхийлж байна. Зах зээлийн шалгуурыг дааж чадаагүй зарим хэсэг нь зах зээлээс шахагдаж байгаа хандлагыг бизнес өргөжөөгүй эсвэл буурч байгаа гэсэн саналууд илэрхийлж байна.

Борлуулалтын зах зээл. Малчдын 97.5 хувь, бизнес эрхлэгчдийн 90.2 хувь нь борлуулалтаа сумынхаа дотор хийдэг байна. Энэ нь тус сум томоохон зах зээлээс алслагдсан байршлын өвөрмөц онцлогтой холбоотой юм. Гурил, тэжээл, спирт, архины үйлдвэрлэл эрхлэгчид ойролцоо сум, аймгийн зах зээлд бүтээгдэхүүнээ гаргадаг байна. Тус сумын бизнес эрхлэгчид цаашдаа үйлдвэрлэлээ өргөтгөж, аймгийн дотоод зах зээлд гаргах бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэх, ялангуяа аймгийн гурил, тэжээлийн хэрэгцээг хангахад илүү их нөлөөтэй оролцох зорилготой ажиллаж байгаа юм. Түүгээр зогсохгүй үндэсний болон гадаад зах зээлийг ч сонирхож байна. Сумынхаа дотоод зах зээлийн чадавхижуулах талаар санаа тавьж ажиллах нь сумын бизнесийн хөгжлийн чухал хүчин зүйл болох магадлалтай. Тус

сум хүн ам олонтой учраас зах зээл хангалттай, худалдан авах чадвар ч муугүй тул суманд борлуулалт өндөр байх үндэслэл болж байна.

Бизнесийн ирээдүйн хэтийн төлөв. Сумын дүнгээр судалгаанд оролцогчдын 98.7 хувь, үүний дотор бизнес эрхлэгчид 100.0, малчдын 97.2 хувь нь бизнесийнхээ ирээдүйг өөдрөг гэж үнэлснийг сэтгэл зүйн болон ирээдүйдээ итгэх итгэл сайн байгаа давуу тал гэж үзэж байна.

Мэргэжилтэй ажиллагсдын хэрэгцээ. Бизнес эрхлэгчдийн 55.0%, малчдын 22.9% нь мэргэжилтэй ажиллах хүч хэрэгцээтэй гэж үзэж байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд залуу малчид цөөрч байгаа нь зовоосон асуудал болж байна. Иймд орон нутагтаа шаардлагатай мэргэжилтэй ажилчин бэлтгэх, сургалт зохион байгуулахад одооноос анхаарал тавьж ажиллах хэрэгтэй болохыг судалгаа харуулж байна.

Бизнесийн цйл ажиллагаатай холбоо бүхий сургалтын эрэлт. Орон нутгийн бизнесийнхэн хамгийн эрэлттэй сургалтын тоонд чадвар сайжруулах, санхүү, бүртгэл, технологи, чанарын хяналт, менежментийн сургалтыг нэрлэж байна. Сургалтын эрэлт их байгаа нь сум, бизнесийн байгууллагуудын зүгээс тодорхой арга хэмжээ зохион байгуулж, ажиллагсдыг бэлтгэх ажил хийдэггүй, мэргэжсэн хүн ажиллуулдаггүй сул тал байгааг харуулж байна.

Бизнесийн өрсөлдөөний үнэлгээ. Судалгаанд хамрагдагсдын үзэж байгаагаар суман дотроо өрсөлдөөн ихтэй, харин аймагт бага, үндэсний хэмжээнд эсвэл импортын бараатай өрсөлдөөн байхгүй ажээ. Бизнес эрхлэгчдийн хувьд энэ нь гадагш өрсөлдөх чадвартай болж буй сайн тал, малчдад бол сул талыг харуулж байна.

Борлуулалтаа сайжруулах арга хэмжээ. Бараа үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах, нэр төрлийг олшруулах, үнээ бууруулах зэрэг тооны өөрчлөлтийг борлуулалтаа нэмэгдүүлэх гол арга зам гэж үзэж, реклам, сав баглаа боодол зэргийг сонирхохгүй байна. Харин бизнес эрхлэгчид захиалагчаа зөв олох, борлуулах цэгээ нэмэгдүүлэх, байршлаа зөв олох асуудалд малчдыг бодвол анхаарал илүү анхаарал хандуулж байна.

Бизнесийг хөгжцүлэхэд бизнесийн холбоо, байгууллагуудын туслалцаа. Судалгаагаар малчид 100%, бизнес эрхлэгчдийн 72.9% нь бизнесийн холбоо, байгууллагууд тусалдаггүй гэсэн байна.

Бизнесээ цаашид өргөжцүлэх сонирхолтой эсэхийг судлахад санал асуулгад оролцсон бүх бизнес эрхлэгчдийн 97.9% нь одоогийн бизнесээ өргөтгөх, 63.6% нь шинээр бизнес эхлэх сонирхолтой гэсэн бол малчдын 97.2% нь одоогийн бизнесээ өргөтгөх, 80.0% нь шинээр бизнес эхлэх сонирхолтой байв. Гэхдээ малчдын 82.5%, бусад бизнес эрхлэгчдийн 74.5% нь сумынхаа дотор, малчдын 17.5% нь аймагт, бусад бизнес эрхлэгчдийн 25.4% өөр аймаг хотод үйлдвэрлэлээ өргөтгөх

сонирхолтой байна. Харин тэдний 88.9% нь эрчимжүүлэх бодолтойгоо илэрхийлжээ. Үүнээс үзвэл малчид малын тоогоо олшруулахын хамт чанарыг нь сайжруулахыг илүү хүсч байгаа бол бизнес эрхлэгчид үйлдвэрлэлийн хэмжээг өргөтгөх, эрчимжүүлэх, чанарыг сайжруулахад ижил түвшинд анхаарал тавьж байна.

Бизнес шинээр эрхлэх сонирхол. Шинээр бизнес эхлэх нь эдийн засгийн өсөлт бий болгох, бизнесийг өргөтгөн хөгжүүлэх нэг чухал алхам мөн. Судалгаанаас үзвэл, малчдын 80%, бизнесүүдийн 63.6% нь шинэ бизнес эхлэх хүсэлтэй байна.


Бизнес өргөтгөх зах зээлийн боломж. Бизнесээ өргөтгөхөд малчдын хувьд сум, аймагт зах зээл хүрэлцээтэй гэж үзэж байгаа бол бусад бизнес эрхлэгчид сумын зах зээлийн багтаамжийг чамлаж байна. Малчид болон бусад бизнес эрхлэгчдийн аль аль нь үндэсний хэмжээний болон гадаад зах зээлийн талаар мэдээлэл бага учраас ач холбогдол өгч үнэлж чадаагүй байна. Эндээс харахад, тус сумын бизнесийн зорилтот зах зээл нь одоогоор сумынхаа хэрэгцээг хангахад илүү чиглэсэн байгаа нь анзаарагдаж байна.

| | Шүүдний хувийн эмнэлэг байгуулах | Эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх болон бизнесийн шинэ салбарыг хөгжүүлэх зорилгоор шүүдний хувийн эмнэлэг байгуулах санаачлагыг дэмжинэ. Шүүдний эмнэлгийн байр, шаардагдах тоног төхөөрөмж, мэргэжлийн эмчээр хангах арга хэмжээг хэрэгжвинэ. | ЗДТГ, утас: 0138251285 Сумын хүн эмнэлгийн салбар |
| | Ерөнхий боловсролын хувийн сургууль байгуулах | Өрсөлдөөний замаар сургуулийн байрын хүрэлцээ, сургалтын чанарыг сайжруулахад ерөнхий боловсролын хувийн сургууль байгуулах нь чухал арга хэрэгсэл гэж үзнэ. Хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүнд сургуулийн байр, сургалтын орчин үеийн тоног төхөөрөмж, мэргэжлийн багш нараар хангах, сургалтын арга, агуулгыг шинэчлэх ажлууд багтана. | ЗДТГ, утас: 0138251285 11 жилийн дунд сургууль Иргэд, аж ахуйн нэгж |

| Үндсэн чиглэл | Дэмжих үйл ажиллагааны чиглэлүүд | Товч тодорхойлолт | Холбоо барих хаяг, утас |
|---|---|---|---|
| Иргэдийн амьдралын орчныг сайжруулах чиглэл | Сумын төвд 20 хүний хүч чадалтай халуун усны газар шинээр барих | Үйлчилгээний хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах зорилготой. Халуун усны барилга, тоног төхөөрөмжөөр хангах, үйлчилгээний олон хэлбэрийг нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Бусад үйлчилгээтэй төв хослон эрхэлж болно. | ЗДТГ, утас: 0138251285 Нийтийн ахуй үйлчилгээний төв |
| | Орчин үеийн стандартад нийцсэн орон сууц барих | Оршин суугчдын орон сууцны хангамжийг сайжруулах зорилгоор нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системд холбогдсон орчин үеийн хүний эрэлт хэрэгцээнд нийцсэн орон сууцны байр барих бизнесийг дэмжинэ. Эхний ээлжинд 50 айлын орон сууцны байр барина. | ЗДТГ, утас: 0138251285 |
| | Малчдыг сэргээгдэх эрчим хүчээр хангах | Малчдын эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж нийлүүлэх, хэрэглэгчдийг сургах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Мөн сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажлыг давхар харууцан ажиллах боломж бүрдүүлнэ. | ЗДТГ, утас: 0138251285 Иргэд, аж ахуйн нэгж |
| Мэдээллийн үйлчилгээг сайжруулах чиглэл | Малчдыг хөдөлгөөнт холбооны системд хамруулах | Малчдыг холбоожуулах арга хэмжээний хүрээнд дамжуулах станц суурилуулах, гар утас, шаардагдах тоног хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээ хүргэх, хэрэглээнд сургах ажлыг хэрэгжүүлнэ. Ажлыг бизнесийн журмаар хэсэгчлэн гүйцэтгэх боломжтой. | ЗДТГ, утас: 0138251285 Аж ахуйн нэгжүүд |
| | Интернет кафе байгуулах | Суманд ажиллаж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүд болон иргэдэд мэдээллийн үйлчилгээ үзүүлэх интернет кафег бизнесийн хэлбэрээр зохион байгуулах ажил хамрагдана. Бусад ажил үйлчилгээтэй давхар эрхэлж болно. | ЗДТГ, утас: 0138251285 Холбооны салбар Иргэд, аж ахуйн нэгж |
| | Орон нутгийн FM радио байгуулах | Иргэдэд сумын дотоод мэдээлэл хүргэх үйлчилгээ үзүүлэх FM радио байгуулах ажлыг уг арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ. Уг үйлчилгээг бусад ажил үйлчилгээтэй давхар буюу дагнан эрхэлж болно. | ЗДТГ, утас: 0138251285 Холбооны салбар Иргэд, аж ахуйн нэгж |

5.9. Төслийн товч танилцуулга

| | | |
|--|--|--|
| № 1 | Төсөл: Зо1:Зт1:Хө1:Т1: Сумын ойн нөөцийн үнэлгээ, нөхөн сэргээлт, ашиглалтын зураглал | Хөтөлбөр: Зо1:Зт1:Хө1: Ойн нөөцийг зөв ашиглах, нөхөн сэргээх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Сумын байгалийн нөөц баялгийн чухал хэсэг нь ойн нөөц юм. Уг нөөцийг урт хугацаанд зөв зохистой ашиглахын тулд ойн нөөцийн үнэлгээ хийж нөөцийн хэмжээг зөв тогтоох, хаана нөхөн сэргээлт хийх, хаанаас хэдий хэмжээний хэрэглээний мод бэлтгэхийг урьдчилан тодорхойлох шаардлагатай болж байна. Ойн нөөцийн үнэлгээ, нөхөн сэргээлт, ашиглалтын зураглал хийснээр дээрх асуудлуудыг шийдэх суурь материалтай болох юм. Энэ ажилд сумын захиргаа, иргэд, мэргэжлийн байгууллага, хүмүүсийн туслалцаа шаардлагатай.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Ойн нөөцийг зохистой ашиглах боломж бүрдүүлнэ. • Нөхөн сэргээлт хийх, мод бэлтгэх газрууд тодорхой болж зөвшөөрөл олголт цэгцтэй болно. • Мод бэлтгэх газруудад төр, олон нийтийн байгууллага, иргэд хяналт тавих боломжтой болно. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд • Бизнес эрхлэгчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Аймгийн байгаль орчны алба | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Бизнес эрхлэгчид • Мэргэжлийн байгууллагууд |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд: шаардлагагүй</p> | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг</p> | | <p>16.0</p> |
| <p>1. Бэлтгэл ажлын зардал</p> <p>2. Мэргэжлийн байгууллага, хүмүүст гэрээгээр олгох</p> | | <p>2.0</p> <p>14.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: Нэг жил</p> | | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа 5–8 жил хэрэглэгдэж, дараа нь шинэчлэн боловсруулна.</p> |

| | | |
|---|---|---|
| № 2 | Төсөл: Зо1:Зт1:Хө1:Т2: Ойн нөхөн сэргээлт, хамгаалал, “Ногоон бүс” төсөл | Хөтөлбөр: Зо1:Зт1:Хө1: Ойн нөөцийг зөв ашиглах, нөхөн сэргээх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Сумын ойн нөөцийг нэмэгдүүлэх, сумын төвийн агаарын бохирдлыг бууруулахад төслийн зорилго чиглэнэ. Энэ төсөл нь ойн нөөцийг нөхөн сэргээх, сумын төвийг цэцэрлэгжүүлэх гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ. Ойн нөхөн сэргээлтийг сумын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоотойгоор мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Сумын төвийг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлын хүрээнд сумын төвийн гол гудамжинд мод тарьж, айл өрх албан байгууллагын орчныг цэцэрлэгжүүлж, иргэдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулалтын газар бий болно. Энэ ажлыг сумын төвийн аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ба хөрөнгийн эх үүсвэр дутагдаж байгаа юм. 2007 онд сумын төвийг цэцэрлэгжүүлэх талаар зохих хэмжээний ажил хийж эхлээд байна.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Ойн нөөцийн хэмжээ буурах явдал багасах • Сумын төвийн цэцэрлэгжилт нэмэгдэж, агаарын бохирдол багасах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Аймгийн байгаль орчны алба • Сумын иргэд, ААН, байгууллага | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Бизнес эрхлэгчид • Хандивлагчид • Мэргэжлийн байгууллагууд |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Нөхөн сэргээлт шаардлагатай газруудыг урьдчилан судалж тогтоох • Орчны иргэд, холбогдох хүмүүсийг мод суулгах ажилд сургах, дадлагажуулах • Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гаргах • Иргэдийн чөлөөт цагийг өнгөрөөх талбай байгуулах газрыг урьдчилан тогтоосон байх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>50.0</p> |
| <ol style="list-style-type: none"> 1. 6000 тарьц худалдан авахад 2. Тарьцыг тарих, хамгаалах, арчлах зардал 3. Сумын төвийг цэцэрлэгжүүлэх ажиллагааны зардал 4. Арчилгаа, урамшуулал, сурталчилгаа,бусад зардал | | <p>7.2 14.0 25.0 3.8</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2009 онд 3 жил</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжиж дууссаны дараа сумын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд уг ажлыг тогтвортой үргэлжлүүлнэ.</p> | |

| | | |
|--|--|--|
| <p>№ 3</p> | <p>Төсөл: Зо1:Зт2:Хө1:Т1: Сумын бэлчээр, тариалан, хадлангийн талбайн ашиглалтын менежментийн журам, зураглал</p> | <p>Хөтөлбөр: Зо1:Зт2:Хө1: ХАА–н зориулалттай газрыг зохистой ашиглах</p> |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Бэлчээр, хадлан, тариалангийн талбайг зөв зохистой ашиглах, бизнес эрхлэгчдийн газарт хандах хандлагыг өөрчлөх зорилгоор бэлчээр, хадлан, тариалангийн газрыг хуваарь, сэлгээтэй ашиглах ажлыг нэг мөр болгон цэгцлэхийн тулд тусгай журам боловсруулж хэрэгжүүлэхэд төслийн үндсэн зорилго оршино. Төслөөр тариалан, хадлан, бэлчээрийн газрын зааг, тэдгээрийг ашиглах журам, төрөл бүрийн зориулалттай эдэлбэр газрыг ашиглагч, эзэмшигч болон сумын төр захиргаанаас газар ашиглалтын талаар хүлээх үүрэг хариуцлагыг хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлж, орон нутагт нэг мөр хэрэгжүүлэх заавар, газрын зургийн хамт боловсруулж, дээрх эдэлбэр газруудын элэгдлийг багасгах арга хэмжээ хэрэгжүүлнэ. Орон нутгийн нөхцөлд зохицсон журамтай болж мөрдүүлснээр бэлчээр, хадлан, тариалангийн талбайг Газрын тухай Монгол улсын хуулийн хүрээнд зөв ашиглах журам хэвшиж, үүний үрээр бэлчээрийн талхлагдал, тариалангийн талбайн элэгдэл багасч, га–ийн ургац нэмэгдэх, улмаар газар ашиглалтын үр ашиг дээшлэх боломж бүрдэнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • ХАА–н эдэлбэр газрыг төрийн зүгээс зохицуулах зохицуулалт нэг мөр болох • Бэлчээрийн талхлагдал, хөрсний үр шим бууралтыг багасгах • Бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх • Бэлчээр, хадлан, тариалангийн талбайтай холбогдсон газрын маргаан багасгах • Газар ашиглалтын үр ашиг дээшлэх | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр бизнес эрхлэгчид • Багийн удирдлага |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Мэргэжлийн байгууллага | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Хандивлагчид |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Бэлчээрийн тухай Монгол улсын хууль батлагдах • Сумын бэлчээр, хадлангийн газрын хянан баталгаа хийх • Газрын даамал, хүнс, хөдөө аж ахуйн ажилтныг сургах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Газрын тухай Монгол улсын хуульд өөрчлөлт орох |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>100.0</p> |
| <p>1. Бэлчээр, хадлан, тариалангийн эдэлбэр газрын элэгдлийг багасгах арга хэмжээ</p> <p>2. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах зардал</p> <p>3. Зураглал хийлгэх, журам боловсруулах зардал</p> | | <p>40.0</p> <p>2.0</p> <p>58.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2006–2008 онд</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа төслийн үр дүн тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|--|--|--|
| <p>№ 4</p> | <p>Төсөл: Зо4:Зт5:Хө1:Т5: Бэлчээр усжуулалт, ашиглалт, усны эх булгийн хамгаалалт</p> | <p>Хөтөлбөр: Зо4:Зт5:Хө1: Бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, ачааллыг жигдрүүлэх</p> |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Худаг ус хүрэлцээгүйгээс бэлчээр жигд бус ашиглагдах, зохистой бус ашиглалтаас байгалийн усны эх үүсвэрүүд хатаж ширгэх, ундрага нь багасах, бохирлогдох, ус ашиглагчдын хооронд маргаан үүсэх зэрэг сөрөг үзэгдэл ихсэх хандлагатай байна. Энэ бүхэн нь бэлчээр, тариалангийн усан хангамжийг дээшлүүлэх, байгалийн болон зориуд бий болгосон усны эх үүсвэрүүдийг хамгаалах, тоог нь олшруулах, хамтаар ашиглах менежмент нэвтрүүлэхийг шаардаж байгаа юм. Төслийн тусламжтайгаар 8 жилийн хугацаанд 45 худаг шинээр гаргах, хуучин худгуудыг засварлах, байгалийн усны эх үүсвэрүүдийг олон нийтийн оролцоотойгоор хамгаалах, нөхөн сэргээх замаар бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, усалгаатай тариалан хөгжүүлэх боломж бүрдүүлэх, ус ашиглах хамтын менежмент нэвтрүүлэх ажлуудыг хэрэгжүүлнэ. Төсвийн хөрөнгө оруулалт, хандивлагчдын хөрөнгөөр худаг уст цэг шинээр гаргах, байгалийн усны эх үүсвэрүүдийг хамгаалах ажил 2007 оноос хийгдэж эхлээд байна.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Инженерийн ба гар худгийн тоо нэмэгдэж, сумын төвийн болон бэлчээрийн усан хангамж сайжрах • Байгалийн усны эх үүсвэрүүдийг төр, олон нийтийн хамгаалалтанд авах • Ус ашиглах хамтын менежмент нэвтэрч маргаан багасах • Усны хууль бүрэн хэрэгжих | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд • Бизнес эрхлэгчид | |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Мэргэжлийн байгууллага • Аж ахуйн нэгжүүд • Нийт иргэд | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Бизнес эрхлэгчид • Хандивлагчид | |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Хамгаалалтанд авах байгалийн усны эх үүсвэрүүдийг урьдчилан тогтоосон байх • Худаг ус цэг шаардлагатай байршлуудыг тогтоосон байх | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> | |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 100.0</p> | | |
| <ol style="list-style-type: none"> 1. Гүн өрмийн инженерийн хийцтэй 12 худаг шинээр гаргах 2. 16 булгийн эхийг хамгаалалтанд авах 3. Бороо, цасны усыг нөөцлөх зардал 4. Худаг гаргах газрыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох зардал 5. Сургалт, судалгаа ,гэрээний зардал | <p style="text-align: right;">92.0 2.0 4.0 0.6 1.4</p> | |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2015 онд 8 жил</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|--|---|--|
| № 5 | Төсөл: Зо1:Зт4:Хө1:Т1: Орон нутгийн байгаль, экологийн зохистой түвшний шалгуур боловсруулах | Хөтөлбөр: Зо1:Зт4:Хө1: Олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Уг төслөөр сумын нутаг дэвсгэрийн одоогийн байгалийн нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлж, ус, ургамал, мод, ан амьтан болон байгалийн нөөцийн тоо хэмжээ, байршлыг нарийн тогтооно. Үүний үрээр ирээдүйд байгалийн экологид гарч болох өөрчлөлтийг хянах, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр байгалийн нөөцийг ашиглах, нөхөн сэргээх нөхцөл боломж бүрдүүлэхэд төслийн зорилго оршино. Төсөл хэрэгжүүлснээр орон нутгийн байгаль, экологийн зохистой түвшний шалгуурыг сумын түвшинд мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар гаргаж, мониторинг хийх арга зүйг боловсруулна.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын байгаль экологид гарч байгаа өөрчлөлтийг хянах хэмжүүртэй болох • Байгаль экологийн өөрчлөлтийг хянах мониторингийн арга зүйтэй болох • Байгалаа унаган төрхөөр нь хадгалах • Байгалийн нөөцийг сөрөг нөлөөгүйгээр ашиглах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Тариалан сумын ЗДТГ • Хөвсгөл аймгийн Байгаль орчны алба | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Хандивлагчид • Мэргэжлийн байгууллагууд |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн албадтай хамтран сургалт зохион байгуулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Орон нутаг дангаараа хэрэгжүүлэх боломжгүй |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 10.0 |
| 1. Байгаль экологийн өнөөгийн бодит байдлын судалгаа хийх | | 3.0 |
| 2. Мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар шалгуур боловсруулах | | 7.0 |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Засаг дарга Ц.Хөвсгөлдалай Засаг даргын орлогч Д.Батжаргал</p> | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 1 жил | | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш |

| | | |
|---|---|--|
| <p>№ 6</p> | <p>Төсөл: Зо1:Зт4:Хө1:Т2: Бүх нийтийн экологийн боловсролын шаталсан сургалт явуулах</p> | <p>Хөтөлбөр: Зо1:Зт4:Хө1: Олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх</p> |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн зохистой ашиглалт хэрэглээ нь иргэд, олон нийтийн ухамсар, экологийн боловсролоос шууд хамаардаг. Иймд тэдний экологийн боловсролыг системтэй дээшлүүлж, байгаль орчинтой зөв харьцаж, зохистой хэрэглээнд сургах явдал чухал шаардлагатай байна. Сургалтыг урьдчилан тодорхойлсон хөтөлбөрийн дагуу шаталсан сургалтаар сумын ЗДТГ-аас аймгийн Байгаль орчны газартай хамтран зохион байгуулж явуулна. Төсөл хэрэгжүүлснээр нийт иргэдийн байгаль экологийн мэдлэг дээшилж, байгаль орчноо хамгаалах, байгалийн нөөц баялгийг зөв ашиглах, эх нутгаараа бахархах сэтгэл зүй төлөвшинө.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Байгальтай зүй бусаар харьцах иргэдийн тоо буурч иргэд өөрсдөө байгаль орчноо хамгаалдаг болно. • Хулгайн ан, хулгайгаар мод ашиглах явдал зогсоно • Иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөл боломж бүрдэнэ. • Байгалийн бүх төрлийн нөөцийг үйлдвэрлэлд зөв зохистой ашиглах дадал бүрдэнэ. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Хөвсгөл аймгийн Байгаль орчны алба | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • 11 жилийн дунд сургууль • Байгаль хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн байгууллага, хандивлагчидтай харилцаа холбоо тогтоож гэрээ байгуулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>11.0</p> |
| <p>1. Сургалтанд шаардлагатай гарын авлага боловсруулах</p> <p>2. Сургалт явуулах зардал</p> | | <p>4.6</p> <p>6.4</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай Засаг даргын орлогч Д.Батжаргал</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2008 онд 1 жил</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Нэг жилийн дараа үр дүн гарч тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|---|---|---|
| № 7 | Төсөл: Зо2:Зт1:Хө1:Т1: Хөдөө аж ахуйн салбарын зохистой харьцаа, хөгжлийн чиг хандлага | Хөтөлбөр: Зо2:Зт1:Хө1: Хөдөө аж ахуйг эрчимжүүлэх бодлогын шинэчлэл |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийн хандлага, орон нутгийн нөөц боломжид түшиглэн ямар салбарыг илүү дэмжин хөгжүүлэх, эрчимжүүлэх бодлого боловсруулахад төслийн үндсэн зорилго оршино. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлоготой болсноор газар ашиглалт сайжирч, улмаар малын тоо толгой, тариалангийн талбай зохистойгоор өөрчлөгдөх, малын ашиг шим, тариалангийн ургац нэмэгдэх боломж бүрдэнэ. Мөн эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл зөрчилгүйгээр зэрэгцэн хөгжих боломж нээгдэнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Мал аж ахуй , газар тариалангийн дотоод салбаруудын хөгжлийн чиглэл тодорхой болох • Үйлдвэрлэлийг орон нутгийн нөхцөл боломжид түшиглэн эрчимжүүлэх аж ахуйн нэгж, иргэдийн санаачлага нэмэгдэх • Мал аж ахуйн, газар тариалан эрхлэгчдийн хоорондын зөрчил арилах, хамтын ажиллагаа сайжрах • Үйлдвэрлэлийн байгалиас шууд хараат байдал буурах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Малчид, тариаланчид • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Хөвсгөл аймгийн ХХААГ • Сумын ЗДТГ • Үйлдвэрлэлийн холбоод | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэлийн холбоод • Хандивлагчид • Иргэд, аж ахуйн нэгжүүд |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Урьдчилсан нөхцөл шаардахгүй | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>4.0</p> |
| <ol style="list-style-type: none"> 1. Тариалан, мал аж ахуйн өнөөгийн байдалд судалгаа хийх 2. Тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх арга ажиллагаа, тэргүүлэх чиглэлийн талаар санал авах уулзалтууд зохион байгуулах 3. Хөгжлийн чин хандлагын баримт бичиг боловсруулах | | <p>1.5 1.0 1.5</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Засаг дарга Ц.Хөвсгөлдалай Засаг даргын орлогч Д.Батжаргал</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 1 жил</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: 1 жилийн дараа</p> | |

| | | |
|------------|--|--|
| № 8 | Төсөл: Зо2:Зт1:Хө1:Т2: Мал эмнэлэг, үржлийн албыг бэхжүүлэх, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйн хөгжлийг бодлогоор дэмжих | Хөтөлбөр: Зо1:Зт2:Хө4: ХАА–г эрчимжүүлэх бодлогын шинчлэл |
|------------|--|--|

Төслийн товч тодорхойлолт: Суманд мал эмнэлэг, мал үржлийн ажил орчин цагийн зах зээлийн шаардлагаас хоцорсон, өндөр ашиг шимт малын тоо нийт малд зөвхөн 0.4%–г эзэлж байгаа зэрэг нь эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бааз суурь, нөхцлийг хангахгүй байна. Мал эмнэлэг нь малчдын хүсэл сонирхолд хүрсэн үйл ажиллагаа явуулахгүй байгаа. Мөн газар тариалангийн үйлдвэрлэлд усалгаатай газар тариалан эрхлэх, сортын шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай болоод байна. Уг төслийг хэрэгжүүлснээр мал эмнэлэг, үржлийн албаны ажлын чанарыг шаардлагын хэмжээнд хүргэх, тариаланчид, малчдын өндөр ашиг шимтэй мал үржүүлэх, шинэ сортын чанартай үрээр тариалах сонирхлыг дээшлүүлэх, тэдэнд өндөр ашиг шимтэй үржлийн мал, нутагшсан сайн сортын чанартай үр олоход нь зуучилж туслах, арга зүйн туслалцаа үзүүлэх талаар сум, багаас баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг тодорхойлно.

| | |
|---|--|
| Хүлээгдэж буй үр дүн: <ul style="list-style-type: none"> ЗДТГ–ын ХХАА, Мал эмнэлэг үржлийн албаны үйлчилгээний чанар сайжирна. Нэг малаас авах ашиг шим, га–аас авах ургацын хэмжээ нэмэгдэх Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн байгалийн эрсдэлийг даван туулах чадвар дээшлэх Тариалан, хадлан, бэлчээрийн өгөөж сайжрах Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэлийн нөхцөл сайжирч, амьжиргаа дээшлэх | Зорилтот бүлэг: <ul style="list-style-type: none"> Малчид, тариаланчид Багийн удирдлага Хувийн мал эмнэлгүүд |
|---|--|

| | |
|--|--|
| Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид: <ul style="list-style-type: none"> Сумын ЗДТГ Хөвсгөл аймгийн ХХААГ | Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд: <ul style="list-style-type: none"> Сумын ЗДТГ Хандивлагчид Малчид Аж ахуйн нэгжүүд |
|--|--|

| | |
|---|---------------------------------------|
| Зэхэц, урьдал нөхцлүүд: <ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон байх Малчид, тариаланчид, ХАА–н мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах | Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй |
|---|---------------------------------------|

| | |
|---|-------------|
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | 20.0 |
| 1. Сумын мал эмнэлгийг бэхжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж | 6.0 |
| 2. Өндөр ашиг шимт малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах | 4.0 |
| 3. Үржлийн өндөр ашиг шимт цөм сүрэг бүрдүүлэх зардал | 10.0 |

Холбоо барих байгууллага, хүн: Ц. Хөвсгөлдэлай, Засаг дарга
Д.Батжаргал, Засаг даргын орлогч

| | |
|--|---|
| Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2012 он | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн анхны жилээс үр дүн гарч цаашид тогтвортой үргэлжилнэ. |
|--|---|

| | | |
|--|--|---|
| № 9 | Төсөл: ЗоЗ:Зт1:Хө1:Т1: Баг, хөдөөгийн хүн амын эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | Хөтөлбөр: ЗоЗ:Зт1:Хө1: Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Тус сум өнөөгийн байдлаар 25 ортой хүн эмнэлгийн нэг салбартай, сумын хэмжээгээр 1 их эмчтэй, хөдөөгийн 5 багт тус бүр нэг бага эмч ажиллаж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн шатлалын анхны тусламжийг нийт иргэдэд чанартай хүргэх боломжгүй болгодог. Бидний санал болгож байгаа төслөөр 800 шахам өрх, 3200 гаруй хүн амтай Мандал багт эрүүл мэндийн төв шинээр барих, хөдөөгийн алслагдсан Давааны ар /сумын төвөөс 75 км/, Ар тархи /сумын төвөөс 80 км/ багт бага эмчийн салбар байгуулах арга хэмжээ төлөвлөгдөж байна. Багийн бага эмчийн салбар байгуулах ажлыг ЗДТГ-аас 2007 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа. Төслийг баг багаар нь, эсвэл арга хэмжээгээр нь хэсэгчлэн хэрэгжүүлэх боломжтой.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Хүн эмнэлгийн үйлчилгээг иргэд шуурхай, чирэгдэлгүй хүлээн авах боломж нэмэгдэнэ. • Хөдөөгийн хүн ам эмнэлгийн хяналтад бүрэн хамрагдаж, өвчлөл багасна. • Хөдөлмөрлөх нөхцөл боломж нэмэгдэнэ. • Сумын эдийн засгийн хөгжилд сайнаар нөлөөлөх нөлөөллүүд бий болно. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Мандал, Давааны ар, Ар тархи багийн иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар • Сумын хүн эмнэлгийн салбар | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Хүн эмнэлгийн салбар • Хандивлагчид |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн төв, багийн бага эмчийн салбарын барилгын зураг төсөв гаргах • Ажиллах боловсон хүчин бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>26.0</p> |
| <p>1. Мандал багийн эрүүл мэндийн төв</p> <p>2. Артархи, Давааны ар багийн бага эмчийн салбар</p> | | <p>10.0</p> <p>16.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Д.Батжаргал, Засаг даргын орлогч Л. Гэрэлхүү, Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2015 он</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой ажиллана.</p> | |

| | | |
|------------|--|---|
| №10 | Төсөл: ЗoЗ:Зт1:Хө1:Т2: Сумын хүн эмнэлгийн үйлчилгээний хүчин чадлын өргөтгөл | Хөтөлбөр: ЗoЗ:Зт1:Хө1: Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах |
|------------|--|---|

Төслийн товч тодорхойлолт: Тариалан сум 6000 гаруй хүн амтай, Улаанбаатар хотоос 500 гаруй км, аймгийн төвөөс 160 гаруй км зайд байдаг. Хүн эмнэлгийн салбар нь 5 их эмчтэй байхаас ганц их эмч ажиллаж байгаа нь өнөөгийн шаардлагыг хангахгүй байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо жил бүр буурахгүй байгаагийн дээр эмнэлгийн боловсон хүчин, тоног төхөөрөмж хангалтгүйгээс эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд хүргэж чадахгүй байна. Онош тодруулах, хэвтэн эмчлүүлэхээр жил бүр олон иргэд аймгийн төв, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот явдаг. Хүн эмнэлгийн үйлчилгээний хүчин чадлыг өргөтгөхөд чиглэсэн тус төслөөр хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүнд сумын хүн эмнэлгийн салбарын барилгад өргөтгөл хийх, тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангах асуудлууд хамрагдаж байна. Төсөл хэрэгжсэн нөхцөлд тус сумын иргэд эрүүл мэндийн үйлчилгээг сумандаа хүртэх боломжтой болох юм. Төслийг хэсэгчлэн хэрэгжүүлэх боломжтой.

| | |
|---|--|
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Хүн эмнэлгийн салбарын байрны хүрэлцээ сайжирна. • Их эмчийн тоо стандартын хэмжээнд хүрнэ. • Эмнэлгийн эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамж сайжирна. • Урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар хүртээмж сайжирна. • Онош тодруулахаар гадагшаа явах иргэдийн тоо буурна. • Иргэдийн өвчлөл буурч, эрүүл амьдрах нөхцөл боломж нэмэгдэнэ. | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
|---|--|

| | |
|---|--|
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газар • Сумын хүн эмнэлгийн салбар | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Сумын ЗДТГ • Хүн эмнэлгийн салбар • Хандивлагчид |
|---|--|

| | |
|--|--|
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн өргөтгөлийн зураг төсөв хийх | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
|--|--|

| | |
|---|--------------|
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | 140.0 |
| 1. Хүн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл | 21.0 |
| 2. 3 их эмч бэлтгэх ажиллуулах зардал | 9.0 |
| 3. Хүн эмнэлэг, эмийн сангийн байрны өргөтгөл | 110.0 |

| | |
|---------------------------------------|--|
| Холбоо барих байгууллага, хүн: | Д.Батжаргал, Засаг даргын орлогч Л. Гэрэлхүү Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч |
|---------------------------------------|--|

| | |
|-----------------------------------|---|
| Хэрэгжүүлэх хугацаа: 4 жил | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ. |
|-----------------------------------|---|

| | | |
|---|--|---|
| №11 | Төсөл: ЗоЗ:Зт1:Хө1:ТЗ: Сумын нийт иргэдийг хамарсан ДОХ, БЗХӨ–ний шинжилгээ | Хөтөлбөр: ЗоЗ:Зт1:Хө1: Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Эмнэлгийн үзлэгт сайн дураараа хамрагддаггүй өвчний нэг нь ДОХ, бэлгийн замын халдварт өвчин юм. Энэхүү төсөл нь ДОХ, БЗХӨ–ний шинжилгээнд сумын нийт иргэдийг хамруулах замаар уг өвчнөөр өвчилсөн иргэдийг илрүүлж эмчилгээнд хамруулах, тархалтыг зогсоох зорилготой болно. Сум, аймгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран иргэдийг бүрэн хамарсан үзлэг хийх, шинжилгээ авах, өвчтэй иргэдийг эмчлэх, тэдэнд зөвлөгөө өгөх, эрүүл иргэдийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд сургах зэрэг арга хэмжээг төслийн хүрээнд хэрэгжүүлнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Өвчтэй иргэдийг илрүүлж эмчилж эрүүлжүүлнэ. • Иргэд уг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэхүүнтэй болно. • ДОХ, БЗХӨ тархах эх үүсвэрийг арилгана. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Аймгийн эрүүл мэндийн газар • Сумын нэгдсэн эмнэлэг | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Хандивлагчид • Сумын хүн эмнэлгийн салбар • Аймгийн эрүүл мэндийн байгууллага |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн эрүүл мэндийн газар, сумын эмнэлгээс мэргэжлийн хүмүүсийг ажиллуулах асуудлыг шийдэх • Үзлэг, шинжилгээний талаар сум, аймгийн эрүүл мэндийн байгууллагын ажлын төлөвлөгөөнд тусгах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>10.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын хүн эмнэлгийн салбар</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: Нэг жил</p> | | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.</p> |

| | | |
|---|--|--|
| №12 | Төсөл: ЗоЗ:Зт2:Хө1:Т1: Сумын төвд зөөлрүүлсэн ус түгээх 2 цэг шинээр байгуулах | Хөтөлбөр: ЗоЗ:Зт2:Хө1: Сумын төвийн усан хангамж, цэвэр, бохир усны системийг сайжруулах |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Сумын төвийн ундны усан хангамж муу, одоо ашиглагдаж буй 2 худгийн усны хатуулаг нь хүнсний эрүүл ахуйн шаардлага хангадаггүйгээс хүн амын эрүүл мэндэд муу нөлөөлдөг. Төслөөр хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүнд гүний худаг 2-ыг нэмж гаргах, худгуудад ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж тавих арга хэмжээ хамрагдаж байна. Төсөл хэрэгжсэнээр сумын төвийн иргэд байгууллагын усан хангамжийн хүрэлцээ, чанар сайжирна. Энэ ажлыг худгийг нэг нэгээр нь гаргах, усжуулах төхөөрөмж тавих гэсэн хэсгүүдэд хуваан хэрэгжүүлж болно.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Хүн ам эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангагдана. • Сумын төвийн усны хангамж сайжирна. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Мэргэжлийн байгууллага | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Сумын ЗДТГ • Хандивлагчид • Мэргэжлийн байгууллагууд |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Ус гарах цэгийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох • Ус зөөлрүүлэх тоног төхөөрөмжийг судлах • Ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж суурилуулах байрыг бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 50.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Одоо ашиглагдаж буй 2 худгийн тоног төхөөрөмж, байрыг шинэчлэн тохижуулах 2.0 2. Ажиллах боловсон хүчнийг сонгон шалгаруулах, сургаж бэлтгэх 0.8 3. Гүний худаг 2-ыг шинээр гаргах 24.0 4. Ус зөөлрүүлэх тоног төхөөрөмжийг худалдан авах, суурилуулах зардал 23.2 | | |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: Хоёр жил | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Ундны усны гачаалаас гарч байнгын ашиглалттай 4 уст цэгтэй болно. | |

| | | |
|---|---|--|
| №13 | Төсөл: ЗоЗ:Зт2:Хө1:Т2: Сумын төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийг цэвэр, бохир усны системд холбох | Хөтөлбөр: ЗоЗ:Зт2:Хө1: Сумын төвийн усан хангамж, цэвэр, бохир усны системийг сайжруулах |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Сумын төвийн байгууллага, аж ахуйн нэгж, орон сууцны айл өрх зөөврийн ус ашигладаг, бохир ус зайлуулах системд холбогдоогүй нь хүн амын эрүүл мэндэд муугаар нөлөөлөхөөс гадна үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд ихээхэн саад бэрхшээл учруулдаг. Иймд эхний ээлжинд сумын төвийн гол гол байгууллага, аж ахуйн нэгж, орон сууцыг цэвэр, бохир усны системд холбох ажлыг төслөөр гүйцэтгэхээр энэхүү төсөлд тусгаж байна. Энэ нь цаашдаа бүх аж ахуйн нэгж байгууллага, гэр хорооллын өрхүүдийг ээлж дараалалтайгаар нэгдсэн системд холбох үндэс болох юм. Төсөл хэрэгжсэнээр ажиллах амьдрах таатай орчин бүрдэнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн байр, орон сууцны нөхцөл сайжирна. • Сумын төвийн иргэдэд эрүүл ахуйн таатай нөхцөл байдал бий болно. • Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах боломж бүрдэнэ. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд • Төсөвт газрууд • ААН • Бизнес эрхлэгчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Мэргэжлийн байгууллага | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Сумын ЗДТГ • Хандивлагчид |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Зураг төсөв бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Улсын төсвийн санхүүжилт олдохгүй байх |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 350.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Цэвэр бохир усны системд холбох болон дулааны шугам сүлжээг шинэчлэх засварлах зураг төсөв хийлгэх 2. Цэвэр бохир усны байгууламж барих 3. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг цэвэр бохир усны системд холбох | | <p>3.0 120.0 227.0</p> |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2009–2013 он | | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа үр дүн нь тогтвортой үргэлжилнэ. |

| | | |
|--|--|---|
| <p>№14</p> | <p>Төсөл: ЗоЗ:Зт2:Хө2:Т1: Хог хаягдлын олон нийтийн дэмжлэгтэй менежмент нэвтрүүлэх</p> | <p>Хөтөлбөр: ЗоЗ:Зт2:Хө2: Хог хаягдлын асуудлыг оновчтой шийдвэрлэх</p> |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Сумын төв, хүн ам олноор оршин суудаг газрын хог хаягдал байгаль орчныг хамгаалах болон хүн амын эрүүл мэнд, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагын үүднээс нэн түрүүн зохистой шийдвэрлэвэл зохих асуудал болж байна. Сумын төвийн хог хаягдлын байнга тэлж байгаа талбайг багасгаж, хашаа хамгаалалттай болгох, тархалтыг зогсоох, айл өрхүүдийн хуурай хогийг хогийн цэгт тээвэрлэн хүргэх, хаягдлыг ялгаж ашиглах, шингэн хаягдлыг хөрсөнд бохирдол үүсгэхгүй зайлуулах зохистой менежмент нэвтрүүлэх, нийт айл өрхүүдийг хог хаягдлын зохистой менежментэд сургах зэрэг арга хэмжээг энэхүү төслөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм. Төсөл хэрэгжүүлснээр хогийг эмх замбараагүй хаядаг асуудлыг бүрэн шийдвэрлэж, байгаль экологийн цэвэр орчин бий болгох, эрүүл аж төрөхөд чухал алхам болно.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Одоогийн хогийн цэгийн талбай хашаа, хамгаалалттай болж, хогийн талбайн тэлэлт, хогийн тархалт зогсох • Хуурай шингэн хог хаягдлыг зайлуулах, ашиглах зохистой менежмент нэвтрэх • Иргэдийн экологийн цэвэр орчинд эрүүл аж төрөх нөхцөл бүрдэх | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Бизнес эрхлэгчид • Нийт иргэд | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Хандивлагчид • Бизнес эрхлэгчид |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд: Шаардлагагүй</p> | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>45.0</p> |
| <p>1. Одоогийн хог хаягдлын талбайг багасгах, хамгаалалт хашаатай болох, харуул хамгаалалт ажиллуулах зардал</p> <p>2. Хог хаягдлыг ялган сортлох, боловсруулах цех байгуулах</p> <p>3. Сумын төвийн хог хаягдлыг тээвэрлэх, иргэдийг сургах зэрэг үйл ажиллагааны урсгал зардал</p> | | <p>5.0</p> <p>30.0</p> <p>10.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2015 он 8жил</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн явцад болон хэрэгжсэний дараа үр дүн нь тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|--|--|--|
| №15 | Төсөл: ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т1: Сумын төвийн гэрэлтүүлэг, хаягжилт | Хөтөлбөр: ЗоЗ:ЗтЗ:Хө1: Иргэдийн амьдрах орчныг сайжруулах |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Одоо сумын төвийн гудамж, талбай нэр, хаяггүй, зориулалтын бус гэрэлтэй, төв гудамжны гол хэсгээс өөр зориулалтын гэрэлтүүлэгтэй гудамж талбай байхгүй, зам талбай тэмдэггүй байна. Төсөл хэрэгжүүлснээр сумын төвийн төв гудамж, гэр хорооллыг гэрэлтүүлэгтэй, бүх гудамж талбайг нэр хаягтай болгох, замыг тээврийн хэрэгслийн болон явган хүний зориулалтаар ялгаж тохижуулах, тэмдэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ингэснээр сумын төв суурин газрын шинж төрхийг олж, иргэдийн аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Гэр хорооллын гудамж талбайн эмх цэгц сайжирч, төр, нийгмийн үйлчилгээг шуурхай хүргэх боломж бүрдэнэ. • Хулгай дээрэм, авто тээврийн гэмт хэрэг зөрчил буурна. • Иргэдийн аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлд чухал алхам болно. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Нийт иргэд | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Бизнес эрхлэгчид • Хандивлагчид • Мэргэжлийн байгууллагууд |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 30.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Сумын төвийн гудамж хорооллыг хаягжуулах 1.4 2. Гахайн хонхор, хойд энгэр, Шооны амыг гэрэлтүүлэх 12.0 3. Төв гудамжийг тохижуулах, гэрэлтүүлэх үйл ажиллагаа 16.6 | | |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2009 онд 2 жил | | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ. |

| | | |
|---|--|--|
| №16 | Төсөл: ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т2: Соёл, урлаг, мэдээллийн төв | Хөтөлбөр: ЗоЗ:ЗтЗ:Хө1: Иргэдийн амьдрах орчныг сайжруулах |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Иргэд чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх байр байхгүйгээс залуучууд архидаж, хөгшчүүл даалуу тоглож цагийг үр ашиггүй өнгөрөөхөөс гадна элдэв гэмт хэрэг зөрчил гарах үндэс болдог. Санал болгож байгаа энэхүү төслөөр сумын төвд иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх соёл урлаг мэдээллийн задгай талбай (зориулалтын өнгөт хавтан материалаар хийгдсэн талбайтай урлаг, мэдээллийн өндөрлөг тавцантай), мөн тухайн байгууламжид шаардагдах барилга объект (голдоо сумын онцлог байдлыг харуулсан гоёмсог өндөрлөгтэй усан оргилууртай) сандал суудал гэрэлтүүлэгтэй, хүүхдийн тоглоомын талбайтай, эргэн тойронд ногоон бүс цэцэрлэгжилттэй төвийг бий болгоно. Ингэснээр иргэд залуучуудын чөлөөт цагаа ая тавтай орчинд өнгөрүүлэх боломж нөхцлийг бүрдүүлнэ. Энэ оноос төв байгуулах талбай гаргаж, мод тарих, зүлэгжүүлэх ажлыг сумын хүчээр эхэлж байна. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тус тусад нь санхүүжүүлж, хэрэгжүүлэх боломжтой.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын өнгө төрх, тохиолт, соёлжилтонд онцгой нөлөө үзүүлнэ. • Иргэд амралт, чөлөөт цагаа зөв соёлтой өнгөрүүлэх, мэдлэг мэдээлэл олж авахад тус дөхөм болно. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Мэргэжлийн байгууллагууд • Иргэд | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Хандивлагчид • Бизнес эрхлэгчид • Мэргэжлийн байгууллагууд |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд: Байхгүй</p> | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>116.0</p> |
| <ol style="list-style-type: none"> 1. Соёл урлаг, мэдээллийн төвийн зураг төсөв хийлгэх 2. Соёл урлаг, мэдээллийн төвийн барилга 3. Соёл урлаг, мэдээллийн төвийн тохижилт | | <p>5.0 90.0 21.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2010 онд</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа үр дүн нь тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|--|---|--|
| №17 | Төсөл: ЗоЗ:ЗтЗ:Хө1:ТЗ: Сумын төв зам, талбайн тохижилт | Хөтөлбөр: ЗоЗ:ЗтЗ:Хө1: Иргэдийн амьдрах орчныг сайжруулах |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдэд сумын төв гудамжийг хатуу хучилттай авто зам замтай болгох, замын хоёр талыг цэцэрлэгжүүлэх, үйлчилгээний цэгүүдийн хаяг рекламыг гэрлэн чимэглэлтэй, явган хүний замтай нийлсэн цардмал талбайтай болгох, төвийн хатуу хучилттай замыг үргэлжлүүлэн 8 км зам тавьж төв замтай холбох арга хэмжээнүүд багтана. Ингэснээр сумын тохижилт, соёлжилт, өнгө үзэмж сайжирч, зам харилцааны боломжит эх суурийг тавина. Энэ ажлыг сумын захиргаа, иргэд, бизнесийн байгууллагууд, мэрэгжлийн байгууллага, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэдэг байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Төслийг хэсэгчлэн хэрэгжүүлж болно.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын дотоод зам харилцаа сайжирна. • Сумын тохижилт, соёлжилт шинэ түвшинд гарна. • Иргэдийн ая тухтай орчинд амьдрах, ажиллах нөхцөл бий болно. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд • Бизнес эрхлэгчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Иргэд • Бизнес эрхлэгчид • Мэргэжлийн байгууллагууд | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Бизнес эрхлэгчид • Хандивлагчид |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан байх • Зураг төсөв гарсан байх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 1500.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Сумын төв замын тохижилт, улсын төв замтай засмал замаар холбох зураг төсөв хийлгэх 2. Хатуу хучилттай замаар төв замтай холбох /8км/ 3. Сумын төвийн хатуу хучилттай авто ба явган хүний зам, орчны тохижилт | | <p>12.0</p> <p>900.0</p> <p>588.0</p> |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2009–2013 онд | | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа үр дүн нь тогтвортой үргэлжилнэ. |

| | | |
|--|--|---|
| <p>№18</p> | <p>Төсөл: ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т4: Сумын төвийн цахилгааны 10/04 квт–ын шугам сайжруулах засварлах</p> | <p>Хөтөлбөр: ЗоЗ:ЗтЗ:Хө1: Иргэдийн амьдрах орчныг сайжруулах</p> |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Сумын төвийн цахилгааны шугам сүлжээнд олон жил засвар үйлчилгээ хийгээгүйгээс шугамын утас, дамжуулах байгууламжууд муудаж, цахилгааны алдагдал, доголдол гарах, хүчдэл тогтворгүйтэх, гал түймэр үүсэх аюултай болжээ. Энэ нь аж ахуйн нэгж байгууллагын хэвийн ажиллагаа, иргэдийн амьдралд таагүй нөлөөлж, сүлжээг цааш өргөтгөх боломжгүй болгож байна. Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний найдвартай ажиллагааг бүрдүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино. Уг төслөөр хэрэгжүүлэх арга хэмжээнд сумын төвийн цахилгааны сүлжээг шинэчлэн засварлах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлууд хамрагдах юм. 2007 оноос шугам сүлжээний засварын урьдчилсан судалгааны ажил эхлээд байна.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Цахилгааны шугам сүлжээний засвар үйлчилгээний зардал багасах • Байгууллага, иргэдийг цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангах • Цахилгааны шугам сүлжээг өргөтгөх боломж бүрдүүлэх | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд • Бизнес эрхлэгчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • ЗДТГ • Эрчим хүчний байгууллага | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний засварын зураг төсөв гаргах • Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн асуудал улсын төсөвт тусгагдахгүй байх |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>50.0</p> |
| <p>1. Сумын төвийн 10/04–ын шугамын шонгуудын хөлийг бетон хөлөөр солих, дамжуулах утсыг шинэчлэх</p> <p>2. Гахайн хонхорын трансформатор шинэчлэх</p> | | <p>40.0</p> <p>10.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2010 он</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа үр дүн тогтвортой байна.</p> | |

| | | |
|--|---|--|
| №19 | Төсөл: ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т5: Сумын төвийн дулааны шугам сүлжээний засвар | Хөтөлбөр: ЗоЗ:ЗтЗ:Хө1: Иргэдийн амьдрах орчныг сайжруулах |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Сумын төвийн дулааны шугам сүлжээ олон жил ашиглагдсанаас дахин дахин засвар шаардаж, ид хүйтний үед доголдол үүсэх болсон байна. Энэ нь аж ахуйн нэгж байгууллагын хэвийн ажиллагаа, иргэдийн амьдралд таагүй нөлөө үзүүлж, сүлжээг цааш өргөтгөх боломжгүй болгож байна. Сумын төвийн дулааны шугам сүлжээний найдвартай ажиллагааг бүрдүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино. Уг төслөөр сумын төвийн дулааны сүлжээг шинэчлэн засварлах, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Уг арга хэмжээний санхүүжилтийг улсын төсөвт тусгуулах ажлыг хөөцөлдөж эхлээд байгаа.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллага, иргэд дулааны найдвартай эх үүсвэрээр хангагдах • Дулааны төвлөрсөн шугамд шинэ барилга, объектийг холбох боломж нээгдэх • Дулааны шугам сүлжээний урсгал засвар үйлчилгээний зардал багасах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд • Бизнес эрхлэгчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • ЗДТГ • Мэргэжлийн байгууллага | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын төвийн дулааны шугам сүлжээний засварын зураг төсөв гаргах • Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн асуудал улсын төсөвт тусгагдахгүй байх |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 40.0 |
| 1. Нийтийн ахуй, үйлчилгээний төвийн уурын зуухны барилгын өргөтгөл, засварын зураг төсөв | | 1.0 |
| 2. Уурын зуухны барилгын засвар өргөтгөл | | 25.0 |
| 3. Тоног төхөөрөмжийн шинэчлэл | | 14.0 |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2009 он | | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа үр дүн тогтвортой байна. |

| | | |
|--|---|---|
| № 20 | Төсөл: Зo3:Зт4:Хө1:Т1: Өндөр уулын бүсэд газар тариалан, мал аж ахуй эрхлэх сургалт явуулах | Хөтөлбөр: Зo3:Зт4:Хө1: Иргэдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Өндөр уулын бүсэд газар тариалан, мал аж ахуй эрхлэх онцлогийг эзэмшүүлэх нь газар тариалан, мал аж ахуйг тус суманд амжилттай хөгжүүлэх чухал нөхцлийн нэг юм. Өндөр уулын бүсэд газар тариалан, мал аж ахуй эрхлэх сургалтанд хамрагдснаар газар ашиглах, уламжлалт мал аж ахуйг эрхлэн хөтлөх явуулах мэдлэг, туршлагаа гүнзгийрүүлэхээс гадна залуу малчид, тариаланчид мал маллах, тариа тарих ухаанд суралцах болно. Сургалтыг төрөлжсөн сургалт, гэрийн сургалт, үзүүлэх сургууль, дадлагажуулалт зэрэг олон хэлбэрээр явуулна. Ингэснээр малчин тариаланчдын аж ахуй эрхлэх чадавхи сайжирч амьжиргааны түвшин дээшлэх боломжтой.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> Газар тариалан, мал аж ахуйг орон нутгийн онцлогт тохируулан эрхлэх чадавхийг малчид тариаланчид эзэмшинэ. Сумын мал аж ахуй, газар тариалангийн хөгжил сайжирна. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> Малчид, тариаланчид Нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> Сумын ЗДТГ ХАА–н нэвтрүүлэх төв Бизнес эрхлэгчид | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> Сумын ЗДТГ Бизнес эрхлэгчид Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> Сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлага боловсруулсан байх Сургалт явуулах багш, сургагч нарыг бэлтгэсэн байх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 5.0 |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2009 он | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн үр дүн төслийн дараа тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|---|--|--|
| № 21 | Төсөл: Зо3:Зт4:Хө1:Т2: Модноос өөр түлш хэрэглүүлж сургах сургалт, сурталчилгаа | Хөтөлбөр: Зо3:Зт4:Хө1: Иргэдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл ахуйн түлшинд модноос өөр зүйл хэрэглэж заншаагүй нь ойн нөөц багасах болон байгаль орчинд сөрөг нөлөөлж байна. Орон нутагт элбэг олдоцтой аргал, хөрзөн, нүүрс хий, хожуул, унанги, шахмал түлшийг модны оронд ашиглах болон бүрэн шаталттай зуухны хэрэглээнд сургах замаар модны хэрэглээг багасгахад төслийн зорилго оршино. Сургалтыг төрөлжсөн сургалт, гэрийн сургалт, үзүүлэх сургууль, дадлагажуулалт зэрэг хэлбэрээр тогтмол явуулна. Түлшний модны хэрэглээг багасгаснаар орон нутгийн байгаль, экологийн хэвийн байдлыг хадгалахад сайн нөлөө үзүүлнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын түлшний модны хэрэглээ багасах • Сумын төвийн агаарын бохирдол багасах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт иргэд • Аж ахуйн нэгж, байгууллага |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ИТХ • Сумын ЗДТГ • Дунд сургууль • Бизнес эрхлэгчид | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Дунд сургууль • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлага, үзүүлэн таниулах материал • Сургалт явуулах багш сургагчдыг бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 14.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Модноос өөр төрлийн түлш хэрэглэх талаар өдөрлөг, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах 2. Шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжих зардал 3. Модноос өөр төрлийн түлш хэрэглэх, ашиглах, үйлдвэрлэх талаар сургалт явуулах | | <p>2.0 1.0 11.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Байгаль орчны байцаагч</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2009 онд</p> | | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн үр дүн төслийн дараа тогтвортой үргэлжилнэ.</p> |

| | | |
|---|---|---|
| № 22 | Төсөл: ЗоЗ:Зт4:Хө1:ТЗ: Эмнэлгийн сайн дурын туслагч бэлтгэх | Хөтөлбөр: ЗоЗ:Зт4:Хө1: Иргэдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Цөөн бүлээр алс зайдуу нутагладаг иргэдэд эмнэлгийн анхан шатны зайлшгүй тусламж газар дээр нь үзүүлэх, өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэрээр асран халамжлах мэдлэг туршлагатай хүн шаардлагатай байдаг. Ийм мэдлэг дадлагыг эмнэлгийн сайн дурын туслагчийн сургалтаар эзэмшүүлэхэд төслийн зорилго оршино. Эмнэлгийн сайн дурын туслагчийн сургалтыг сумын эмнэлгийг түшиглүүлэн төрөлжсөн сургалтын хэлбэрээр зохион байгуулна. Сургалтад асран халамжлагч шаардлагатай гэр бүлийн гишүүд болон тодорхой нутаг дэвсгэрийн төлөөллийг хамруулна. Мөн сургуулийн сурагчдын дунд сонгон суралцах хичээл явуулах боломжтой.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэдийн эрүүл мэндийн анхан шатны мэдлэг дээшлэх • Эмнэлгийн шатлалын тусламж үйлчилгээ иргэдэд ойртох | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт иргэд • Нийгмийн эмзэг бүлгийн иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Сумын хүн эмнэлгийн салбар | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Бизнес эрхлэгчид • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлага, үзүүлэн таниулах материал • Сургалт явуулах багш сургагчдыг бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 3.0 |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын хүн эмнэлгийн салбар | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2009 он | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн үр дүн төслийн дараа тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|--|---|--|
| № 23 | Төсөл: ЗоЗ:Зт4:Хө1:Т4: Бүх нийтийн эрүүл мэндийн сургалт явуулах | Хөтөлбөр: ЗоЗ:Зт4:Хө1: Иргэдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Иргэдийн эрүүл мэндийн мэдлэг хангалтгүйгээс эрүүл мэндээ хамгаалахад хангалттай анхаарал тавьж чадахгүй байна. Бүх нийтийн эрүүл мэндийн сургалтаар өөрийгөө болон бусдыг чийрэгжүүлэх, зөв хооллох, ажиллаж амьдрах, халдварт болон ердийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, чадвар, дадлыг иргэдэд эзэмшүүлнэ. Сургалтыг сумын эмнэлгийг түшиглүүлэн олон нийтийн арга хэмжээ, гэрийн сургалт, сурталчилгааны хэлбэрээр зохион байгуулна. Сургалтад сонирхсон иргэдийг сайн дурын үндсэн дээр хамруулна. Сургалтыг жил бүр явуулах бөгөөд жил жилээр нь, эсвэл тодорхой бүлэг асуудлаар санхүүжүүлэх боломжтой.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэдийн эрүүл мэндийн анхан шатны мэдлэг сайжрах • Иргэдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг хамгаалах чадавхи дээшилж, өвчлөл багасах | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт иргэд | |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Сумын хүн эмнэлгийн салбар | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Бизнес эрхлэгчид • Хандивлагчид | |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлага, үзүүлэн таниулах материал • Сургалт явуулах багш сургагчдыг бэлтгэх | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> | |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 8.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Сургалт хөтөлбөр, сургалтын гарын авлага, үзүүлэн таниулах материал бэлтгэх 2. Сургалт явуулах 3. Бусад зардал | <p>3.0 4.8 0.2</p> | |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын хүн эмнэлгийн салбар | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2015 он | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн үр дүн төслийн дараа тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|--|--|---|
| <p>№ 24</p> | <p>Төсөл: ЗоЗ:Зт4:Хө1:Т5: Өрхийн үйлдвэрлэл (амьдрах ухааны) хөгжүүлэх сургалт явуулах</p> | <p>Хөтөлбөр: ЗоЗ:Зт4:Хө1: Иргэдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх</p> |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Энэхүү төсөл нь уламжлалт гэрийн үйлдвэрлэлийг орчин үеийн нөхцөл тохируулан хөгжүүлэх, өрхийн орлогыг дээшлүүлэхэд туслах зорилготой. Өрхийн түвшинд болон жижиг үйлдвэрлэлийн журмаар эрхлэх боломжтой мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэл, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн хадгалах, боловсруулах, шинэ техник технологи нэвтрүүлэх, гутал хувцас оёх, хоол унд, үйлдвэрлэлийн багаж тоног хэрэгслээ бэлтгэх, ойр зуурын техник, тоног төхөөрөмжийн засвар хийх, үйлчилгээ эрхлэх, гэр бүлийн тооцоо хийх зэрэг чиглэлээр сургалтыг явуулна. Сургалтыг төрөлжүүлэн үе шаттайгаар зохион байгуулж, сонирхсон иргэдийг сайн дурын үндсэн дээр хамруулна.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэдийн аж ахуй эрхлэх мэдлэг, чадвар дээшлэх • Тэргүүн туршлага, ажлын шинэ арга барил эзэмшүүлэх, солилцох • Мөнгөө зөв зарцуулж сурах • Өрхийн орлого нэмэгдэх | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • ХАА–н нэвтрүүлэх төв | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Бизнес эрхлэгчид • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлага, үзүүлэн таниулах материал • Сургалт явуулах багш сургагчдыг бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>8.0</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2015 он</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа сургалт төлбөртэйгээр тогтвортой үргэлжилнэ.</p> | |

| | | |
|--|--|--|
| № 25 | Төсөл: Зо3:Зт4:Хө2:Т1: Сурагчдыг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж мэргэжилтэй ажилчин бэлтгэх | Хөтөлбөр: Зо3:Зт4:Хө2: Мэргэжилтэй ажилчин бэлтгэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудад мэргэжилтэй ажиллах хүч дутагдалтайг судалгааны дүн харуулж байна. Мэргэжилтэй ажиллах хүчийг сум орны нөхцөлд тохируулан бэлтгэх ажлыг дунд сургуулийг түшиглүүлэн хэрэгжүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино. Сургуулийн сурагчдыг нэмэлт сургалтад хамруулах замаар төрөл бүрийн мэргэжлийн чиг баримжаа, ажлын дадлага туршлага олгож, мэргэжилтэй ажилчин бэлтгэнэ. Төслийн үйл ажиллагааны бүрэлдэхүүнд мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэх талаар сургалтын хөтөлбөрт тусгах, хичээлийн байрын өргөтгөл, тохижилт, сургалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн багш нараар хангах асуудлууд хамрагдаж байгаа болно.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Суманд шаардлагатай мэргэжилтэй ажиллах хүчний хангамж сайжрах • Залуучууд мэргэжлийн чиг баримжаа, ажлын дадлага туршлагатай болох • Ажилгүйдэл, ядуурал буурах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Дунд сургуулийн сурагчид • Бизнес эрхлэгчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Дунд сургууль | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Сумын ЗДТГ • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлага, үзүүлэн таниулах материал • Дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах • Сургалт явуулах багш нарыг бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудал шийдэгдэхгүй байх |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 100.0 |
| 1. Сургалт явуулах багшийг бэлтгэх | | 2.0 |
| 2. Сургалтын байрыг өргөтгөл | | 50.0 |
| 3. Сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл | | 48.0 |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2009–2015 он | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа сургалт тогтвортой үргэлжилнэ. | |

| | | |
|---|--|--|
| № 26 | Төсөл: ЗoЗ:ЗтБ:Хө1:Т1: Сургууль, дотуур байрын өргөтгөл, засвар | Хөтөлбөр: ЗoЗ:ЗтБ:Хө1: Боловсролын үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Одоо сумын дунд сургууль 2 ээлжээр хичээллэж, 100 гаруй хүүхэд дотуур байраар хангагдаагүй байна. Сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материал орчин үеийн шаардлагаас хол хоцорч байна. Энэ нь сургалтын чанарт сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Сумын сургуулийн байр, техник, тоног хэрэгслийн бүхий л нөхцлийг үндэсний стандартын хэмжээнд хүргэж, сургалтын чанарыг сайжруулахад төслийн зорилго оршино. Уг төслөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүнд дунд сургуулийн хичээлийн ба дотуур байрын өргөтгөл, одоо байгаа байрын их засвар, мэргэжлийн багш нараар хангах, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материалын хангамжийг сайжруулах асуудал багтаж байгаа болно. Төслийг хэсэгчлэн хэрэгжүүлэх боломжтой.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын сургуулийн сургалт явуулах нөхцөл үндэсний стандартад хүрэх • Сургалтын чанар дээшлэх • Багшлах бүрэлдэхүүний хангамж, чанар сайжрах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Дунд сургуулийн сурагчид • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Сумын ЗДТГ • Дунд сургууль | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургуулийн хичээлийн ба дотуур байрын өргөтгөлийн зураг төсөв гаргах • Сургуулийн одоо байгаа хичээлийн ба дотуур байрын их засварын төсөв хийх • сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материалын хангамжийг сайжруулах санал, төсөв бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн асуудал улсын төсөвт тусгагдахгүй байх |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 570.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Хичээлийн байрын өргөтгөл, засвар, тохижуулалт 2. Дотуур байрны өргөтгөл, засвар, тохижуулалт 3. Сургалтын техник хэрэгслэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материалын хангамжийг сайжруулах 4. Багш нарын хангамжийг сайжруулах, мэргэжил дээшлүүлэх | | <p>300.0</p> <p>200.0</p> <p>40.0</p> <p>30.0</p> |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Дунд сургуулийн захиргаа | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2010 он | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа сургуулийн үйл ажиллагааны сайжралт тогтвортой байна. | |

| | | |
|--|--|---|
| № 27 | Төсөл: ЗоЗ:ЗтБ:Хө1:Т2: Электрон номын сан байгуулах | Хөтөлбөр: ЗоЗ:ЗтБ:Хө1: Боловсролын үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Сумын номын сангийн мэдээллийг электрон хэлбэрт шилжүүлэх, цаашид мэдээллийг электрон хэлбэрээр хүлээн авах боломж бүрдүүлэх, интернэтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд төслийн зорилго оршино. Уг төслөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүнд номын сангийн байрын тохижилт, тоног төхөөрөмжийн хангамж, номын сангийн мэдээллийг электрон хэлбэрт шилжүүлэх, номын санг интернэтийн сүлжээнд холбох, номын санчдыг давтан сургах, дадлагажуулах ажил багтаж байгаа болно.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах • Мэдээллийн хадгалалт сайжрах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Номын сан | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Номын сангийн байрын засвар • Номын санчдыг сургалтад хамруулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | 12.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Номын сангийн байрыг тохижуулах 2. Техник тоног төхөөрөмж авах суурилуулах 3. Номын санчдыг сургах, дадлагажуулах | | <p>2.0 9.5 0.5</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 1 жил</p> | | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа номын сангийн үйлчилгээний сайн үр дүн тогтвортой хадгалагдана.</p> |

| | | |
|---|--|--|
| № 28 | Төсөл: ЗоЗ:ЗтБ:Хө1:ТЗ: Сургуулийн өмнөх сургалтын байгууллагын байрын өргөтгөл, тохижилт | Хөтөлбөр: ЗоЗ:ЗтБ:Хө1: Боловсролын үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Байр хүрэлцээгүйгээс хамрагдвал зохих насны хүүхдийн 52.3% нь цэцэрлэгт хамрагдаж байгаа бөгөөд цэцэрлэгийн тохижилт, тоног төхөөрөмжийн хангамж орчин үеийн эрэлт шаардлагад нийцэхгүй болсноос хүүхдийн хамрагдалт ийнхүү доогуур хэвээр байна. Цэцэрлэгийн байр, техник, тоног хэрэгслийн нөхцлийг сайжруулж, хүүхдийг сургуулийн өмнөх сургалтад хамрах хүрээг өргөтгөхөд төслийн зорилго оршино. Уг төслөөр цэцэрлэгийн байрыг өргөтгөх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материалын хангамжийг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Сургуулийн өмнөх боловсролын тогтолцоонд сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг хамрах хүрээ өргөжих • Сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанар дээшлэх | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд • Цэцэрлэгийн насны хүүхдүүд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Сумын ЗДТГ • Сумын цэцэрлэг | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн байрын өргөтгөлийн зураг төсөв гаргах • Цэцэрлэгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материалын хангамжийг сайжруулах санал, төсөв бэлтгэх | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн асуудал улсын төсөвт тусгагдахгүй байх |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 200.0 |
| <ol style="list-style-type: none"> 1. Цэцэрлэгийн байрны зураг төсвийн зардал 4.0 2. Цэцэрлэгийн байрны өргөтгөл болон одоогийн байрны их засвар 160.0 3. Нүүдлийн цэцэрлэг байгуулах зардал 14.0 4. Зөөлөн эдлэл, ширээ сандал, техник тоног төхөөрөмжийн зардал 22.0 | | |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Цэцэрлэгийн захиргаа | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2009–2011 он | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа цэцэрлэгийн үйл ажиллагааны сайжралт тогтвортой байна.</p> | |

| | | |
|--|--|--|
| № 29 | Төсөл: ЗоЗ:ЗтБ:Хө1:Т1: Орон нутгийн дотоод замын засвар, сайжруулалт: Шивэртийн даваа, Далтын даваа | Хөтөлбөр: ЗоЗ:ЗтБ:Хө1: Орон нутгийн дотоодын хатуу дэд бүтцийг хөгжүүлэх |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Замын нөхцөл муугаас хөдөөгийн алслагдсан 2 багийн иргэдэд бүтээгдэхүүнээ борлуулах, төрийн үйлчилгээ авах, соёл ахуйн үйлчилгээнд хүрэхэд нь бэрхшээл учирч, бусад багаас илүү хүнд нөхцөлд ажиллаж амьдарч байна. Хоёр багийн иргэдийн үйлдвэрлэл, ахуйн нөхцлийг бусадтай адил болгон сайжруулахад төслийн зорилго оршино. Санал болгож буй төслөөр Шивэртийн давааны 20 км, Далтын давааны 15 км замыг засч сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ. Уг ажлын зарим хэсгийг 2007 оноос орон нутгийн хүчээр хийж эхэлсэн боловч хөрөнгө хүрэлцэхгүй байгаа. Уг арга хэмжээг хэсэгчлэн хэрэгжүүлж болно.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> Хөдөөгийн 2 багийн иргэдийн бүтээгдэхүүнээ борлуулах, үйлчилгээнд хүрэх нөхцөл сайжрах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> Сумын нийт иргэд Давааны ар, Ар тархи багийн иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> Сумын ЗДТГ Давааны ар, Ар тархи багийн иргэд | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> Засгийн газар Сумын ЗДТГ Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> Шивэрт, Далтын давааны засварын зураг төсөв гаргах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 200.0 |
| 1. Зураг төсвийн үнэ | | 6.0 |
| 2. Шивэртийн давааг 20 км газарт стандартын хэмжээнд засварлах | | 90.0 |
| 3. Далтын давааг 15 км газарт стандартын хэмжээнд засварлах | | 70.0 |
| 4. 15 гүүрийг засварлах, 4 гүүр шинээр барих | | 34.0 |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2007–2010 он</p> | | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа иргэдэд хүрэх үр өгөөж тогтвортой байна.</p> |

| | | |
|---|---|--|
| № 30 | Төсөл: 3о3:3т6:Хө1:Т2: Ар тархи, Баянхушуу багийг эрчим хүчний төвлөрсөн системд холбох | Хөтөлбөр: 3о3:3т6:Хө1: Орон нутгийн дотоодын хатуу дэд бүтцийг хөгжүүлэх |
| Төслийн товч тодорхойлолт: Найдвартай эрчим хүчний эх үүсвэртэй болгох замаар Ар тархи, Баянхушуу багийн иргэдийн үйлдвэрлэлийн болон ахуйн нөхцлийг сайжруулахад төслийн зорилго оршино. Энэ төслөөр Ар тархи, Баянхушуу багийг хүртэл өндөр хүчдэлийн шугам татах, дэд станц байрлуулах, хэрэглэгчдийг эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлнэ. | | |
| Хүлээгдэж буй үр дүн: <ul style="list-style-type: none"> • Ар тархи, Баянхушуу багийн иргэдийн ахуйн нөхцөл сайжрах • Ар тархи, Баянхушуу багийн өрхийн үйлдвэрлэл өргөжих, ажлын байр бий болгох | | Зорилтот бүлэг: <ul style="list-style-type: none"> • Ар тархи, Баянхушуу багийн иргэд |
| Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид: <ul style="list-style-type: none"> • Засгийн Газар • Сумын ЗДТГ • Мэргэжлийн байгууллага | | Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд: <ul style="list-style-type: none"> • Засгийн Газар |
| Зэхэц ба урьдал нөхцлүүд: <ul style="list-style-type: none"> • Ар тархи, Баянхушуу багийг эрчим хүчний төвлөрсөн системд холбох зураг төсөв гаргах | | Эрсдэлтэй хүчин зүйлс: <ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн асуудал улсын төсөвт тусгагдахгүй байх |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 150.0 |
| 1. Ар тархи, Баянхушуу багийн төвийг эрчим хүчний төвлөрсөн системд холбох зураг төсвийн зардал | | 8.0 |
| 2. Ар тархи, Баянхушуу багийг эрчим хүчний төвлөрсөн системд холбох зардал | | 142.0 |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2009–2013 он | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа иргэдэд хүрэх үр дүн тогтвортой хадгалагдана. | |

| | | |
|---|---|--|
| № 31 | Төсөл: ЗоЗ:ЗтБ:Хө2:Т1: Ар тархи, Давааны ар багуудын төрийн ба ахуйн үйлчилгээний төвийн барилга барих | Хөтөлбөр: ЗоЗ:ЗтБ:Хө2: Хөдөөгийн багийн тохижилт |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Хөдөөгийн багийн тохижилт муу, зориулалтын барилга байргүйгээс хөдөөгийн малчид төрийн болон ахуйн үйлчилгээг тогтмол хүртэх боломж хомс байдаг. Бизнес эрхлэгчид ч малчдад хүрч үйлчилгээ үзүүлдэггүй. Явуулын журмаар үзүүлсэн үйлчилгээ нь илүү үнэтэй болдог. Багийн төвд төрийн болон ахуйн үйлчилгээ явуулах байртай болгох замаар малчдад хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд төслийн зорилго оршино. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүнд Ар тархи, Давааны ар багийн төвүүдэд багийн удирдлага, мэдээллийн төв, халуун ус, худалдаа, ахуйн үйлчилгээ ажиллуулах байр барих, зориулалтын дагуу тохижуулах ажил багтаж байгаа болно.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> Малчдад төрийн болон ахуйн үйлчилгээ хүртээх боломж сайжрах Нутгийн захиргааны байгууллага, малчдын холбоо өргөжих | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> Ар тархи, Давааны ар багийн иргэд Бизнес эрхлэгчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> Сумын ЗДТГ Мэргэжлийн байгууллага Бизнес эрхлэгчид | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> Засгийн Газар Сумын ЗДТГ Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> Багийн төвийн үйлчилгээний байрын зураг төсөв боловсруулж батлуулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> Улсын төсвийн санхүүжилт олдохгүй байх |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 250.0 |
| <ol style="list-style-type: none"> Ар тархи, Давааны ар багийн төрийн ба ахуйн үйлчилгээний төвийн барилгын зураг төсвийн зардал 12.0 Ар тархи багийн халуун ус, мэдээллийн төв, ахуй үйлчилгээ явуулах байрын барилга, тоног төхөөрөмжийн зардал 105.0 Давааны ар багийн халуун ус, мэдээллийн төв, ахуй үйлчилгээ явуулах байрын барилга, тоног төхөөрөмжийн зардал 105.0 Багийн төвийн орчны тохижилт, гэрэлтүүлэг, цэцэрлэгжүүлэлт 28.0 | | |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 2009–2010 онд 2 жилд</p> | | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа багийн үйлчилгээний үр дүн тогтвортой хадгалагдана.</p> |

| | | |
|---|--|--|
| <p>№ 32</p> | <p>Төсөл: Зо4:Зт1:Хө1:Т1: “Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах”</p> | <p>Хөтөлбөр: Зо4:Зт1:Хө1: Төрийн үйлчилгээг шуурхай болгох</p> |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Хөвсгөл аймгийн Тариалан сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийг сумын нөөц боломжид тулгуурлан газрын зураг дээр тодорхойлно. Ерөнхий төлөвлөгөөнд сумын газар эдэлбэр, ой, бэлчээр, хадлан, тариалан, хот суурины эдэлбэр газрын өөрчлөлт, бэлчээр хадлан, тариалангийн талбайн ашиглалт, ургац, мал аж ахуйн салбаруудын байршил, усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, зам, барилга, холбоо, эрчим хүч, бохир, цэвэр усны шугамын хөгжлийг улсын, бүсчилсэн хөгжлийн ба аймаг, орон нутгийн төлөвлөгөөтэй уялдуулан тодорхойлно. Ингэснээр сумын хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх, цаашид тогтвортой үргэлжлүүлэх үндсэн нөхцлийг бүрдүүлнэ. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсноор эдийн засаг бизнесийн хөгжлийн эрх зүйн орчин бүрдэнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болох • Бизнесийн хөгжлийн нөөцийг оролцогчдод өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх • Үндэсний болон аймаг, орон нутгийн төлөвлөгөөний уялдаа холбоог хангах • Бүх аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгч, иргэдэд хөгжлийн ижил боломж олгох • Ил тод нээлттэй байдлыг хангах | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Нийт оролцогчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газар • Хандивлагчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулах • Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар сумын хөгжлийн чиг баримжааг тодорхойлох | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | | <p>15.0</p> |
| <p>1. Бэлтгэл ажил</p> <p>2. Төлөвлөгөө боловсруулах</p> <p>3. Сурталчилгаа, мэдээлэл</p> | | <p>1.1</p> <p>12.0</p> <p>1.9</p> |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: 3 сар</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа 2015 он хүртэл тогтвортой хадгалагдана</p> | |

| | | |
|---|---|---|
| № 33 | Төсөл: Зо4:Зт1:Хө1:Т2: Нутгийн захиргааны байгууллагын байрын шинэчлэл | Хөтөлбөр: Зо4:Зт1:Хө1: Төрийн үйлчилгээг шуурхай болгох |
| <p>Төслийн товч тодорхойлолт: ИТХ, ЗДТГ үйл ажиллагаа явуулах зориулалтын байргүй, олон жижиг байранд хуваагдан тархсан байдалтай ажиллаж байна. Энэ нь төрийн үйлчилгээг иргэдэд хүртээх, үйлчилгээний шинэ хэлбэрийг судалж нэвтрүүлэхэд бэрхшээл учруулдаг. Төрийн албан хаагчдын ажлын нөхцөл ч хангалтгүй байдаг. Нутгийн захиргааны байгууллагыг зориулалтын байртай болгох замаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэхэд төслийн зорилго оршино. Санал болгож буй төслөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүнд нутгийн захиргааны байгууллагын байрын барилга, тохижилтын ажил багтаж байгаа болно.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний нөхцөл дээшилж, чирэгдэлгүй нээлттэй болно. • Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирч, бүтээмж дээшилнэ • Төрийн үйлчилгээний шинэ хэлбэрүүд нэвтрүүлэх боломж нэмэгдэнэ. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын нийт иргэд |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн Газар |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Нутгийн захиргааны байгууллагын байрын зураг төсөв боловсруулж батлуулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс:</p> <ul style="list-style-type: none"> • Улсын төсвийн санхүүжилт олдохгүй байх |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 150.0 |
| 1. Орон нутгийн төрийн байгууллагын байрын зураг төсвийн зардал | | 10.0 |
| 2. Барилга, гадна, дотоод тохижилт, тавилга | | 140.0 |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2 жил | | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа үр дүн тогтвортой хадгалагдана.</p> |

| | | |
|---|---|---|
| № 34 | Төсөл: Зо4:Зт1:Хө1:Т1: “Төрөөс үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ” | Хөтөлбөр: Зо4:Зт1:Хө1: Төрийн үйлчилгээг шуурхай болгох |
| <p>Төслийн товч тодорхойлолт: Иргэд, бизнес эрхлэгчид, сонирхсон бусад хүмүүст албан ажлын ба туслан дэмжих чиглэлээр үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээ” нээж, бизнесийн орчны таатай байдлыг улам сайжруулахад төслийн зорилго чиглэнэ. Бизнестэй холбоотой шаардлагат мэдээлэл, албан үйлчилгээ болон зөвлөх үйл ажиллагаа эрхлэх нь тус цэгийн үйл ажиллагаа байх болно. Төслөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүнд иргэдэд үйлчилдэг албан хаагчдыг нэг дор төвлөрүүлэх, компьютержуулах, бизнес эрхлэгчдийг нэгдсэн программ хангамжаар үйлчлэх, бизнесийг дэмжих албыг өргөтгөх, интернет, FM радиогоор мэдээлэл авах, дамжуулах үйлчилгээ зэрэг арга хэмжээ багтана. Ийм цэгтэй болсноор хүмүүс бизнестэй хамааралтай бүх төрлийн үйлчилгээг нэг цэгээс авах таатай боломж бүрдэн, төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг дээшилнэ.</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн үйлчилгээ хялбар шуурхай болох • Бизнес холбогдолтой үйлчилгээ нэг газар төвлөрнө • Үйлчилгээний чанар сайжирч үр ашиг нь дээшилнэ • Хүнд суртал багасч ил тод байдал дээшилнэ • Авилгал, хээл хахууль гарах боломж арилна | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт иргэд • Бизнес эрхлэгчид • ЗДТГ | |
| <p>Төсөлд хамргдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ИТХ • Сумын ЗДТГ | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ЗДТГ • Хандивлагчид • Бизнес эрхлэгчид | |
| <p>Зэхэц, урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Ажил явуулах байрын асуудлыг шийдвэрлэх | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> | |
| <p>Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</p> | <p>30.0</p> | |
| <ol style="list-style-type: none"> 1. Зохион байгуулалтын зардал 2.0 2. Байрын засвар, тохижилт 8.0 3. Техник, тоног төхөөрөмж 20.0 | | |
| <p>Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ, Засаг дарга Ц.Хөвсгөлдалай Засаг даргын орлогч Д.Батжаргал</p> | | |
| <p>Хэрэгжүүлэх хугацаа: Нэг жил</p> | <p>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой хадгалагдана.</p> | |

| | | |
|---|--|--|
| № 35 | Төсөл: Зо4:Зт2:Хө1:Т2: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зориулсан сумын хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, зориулалтыг өргөтгөх | Хөтөлбөр: Зо4:Зт2:Хө1: Бизнесийн үйл ажиллагааг дэмжих |
| <p>Төсийн товч тодорхойлолт: Сумандаа жижиг дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэхэд орон нутгийн захиргааны байгууллагаас санхүүгийн туслалцаа үзүүлэхэд зориулсан хөрөнгийн эх үүсвэрийг сумын хөгжлийн сангийн хэлбэрээр бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд одоогоор уг сангийн эх үүсвэр нь дорвитой дэмжлэг үзүүлэх хэмжээнд хүрээгүй байгаа юм. Энэ сан нь аж ахуйн нэгж, иргэдэд зээл олгох, тэдний үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа явуулах зорилготой. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зориулсан сумын хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлснээр сум орон нутгаас бизнес эрхлэгчдэд илүү өргөн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдэнэ. Сангийн эх үүсвэрийг нутгийн бизнес эрхлэгчид, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, хандивлагчдын тусламжтайгаар нэмэгдүүлэхээр төлөвлөж байна</p> | | |
| <p>Хүлээгдэж буй үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын хөгжлийн сангийн эх үүсвэр нэмэгдэнэ. • Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд үзүүлэх тусламж дэмжлэг нэмэгдэнэ. | | <p>Зорилтот бүлэг:</p> <ul style="list-style-type: none"> • Бизнес эрхлэгчид |
| <p>Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын ИТХ • Сумын ЗДТГ • Бизнес эрхлэгчид | | <p>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн Газар • Сумын ЗДТГ • Хандивлагчид • Бизнес эрхлэгчид |
| <p>Зэхэц ба урьдал нөхцлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Орон нутгийн бизнесүүд, хандивлагчдыг судлах • Сангийн хөрөнгийг зарцуулах журам боловсруулах | | <p>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</p> |
| Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: | | 100.0 |
| Холбоо барих байгууллага, хүн: Сумын ЗДТГ | | |
| Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2015 он | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Нэг жилийн дараагаас үр дүн нь гарч цаашид тогтвортой хадгалагдана. | |